

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

НЭГ. ОРШИЛ	3
ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	4
1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр өгсөн санал, дүгнэлт.....	5
2. Төсвөөс гадуурх санхүүжилтийн талаарх танилцуулга, зөвлөмж	7
3. Төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн санал, зөвлөмж.....	8
4. Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд өгсөн санал, зөвлөмж.....	10
5. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, санал	11
6. Цаг үеийн зарим асуудлын талаар	14
ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА	15
ДӨРӨВ. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ	20
ТАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА	20

НЭГ. ОРШИЛ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) нь 2021 онд төсөв, санхүү, эдийн засгийн байдлыг сайжруулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилго тавьж УИХ, түүний Төсвийн байнгын хорооноос тогтоосон¹ бүрэн эрхийнхээ хүрээнд үйл ажиллагаа явууллаа. Тус тайлант жилийн зарим онцлог зүйлээс товч толилуулъя.

- Тайлант 2021 он бол Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны эцсээр оруулсан "... Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно" гэсэн заалтыг хэрэгжүүлж эхэлсэн анхны жил байлаа. Энэхүү нэмэлт нь УИХ-аас төсвийн сахилгыг бэхжүүлэх, Засгийн газрын төсвийн талаарх эрх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, түүнээс төсвийн тэнцлийг хангахыг шаардах түлхэц болсон гэж харж байгаа юм.
- Тайлангийн жилд зарчмын шинжтэй бас нэг нааштай хандлага бол төсвийн шалгууруудыг Засгийн газрын санаачилгаар УИХ байнга өөрчилж ирсэнд дүгнэлт хийж, улс орны эдийн засгийн нөхцөл байдал сайжрах хүртэл тэдгээрийг түр түдгэлзүүлж байх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг чандлан мөрдүүлж байх нэгдсэн ойлголтод холбогдох улс төрийн болон мэргэжлийн байгууллагууд, зарим олон нийтийн төлөөлөл хүрсэн гэж үзэж байна. Байгалийн баялгаа эрчимтэй ашиглаж байх үедээ эдийн засагтаа хуримтлал үүсгэж, ирээдүйн хөгжлийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх зарчмыг тогтоосон 2010 оны Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн ач холбогдол өнөөдөр улам бүр нэмэгдэж байна.
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсөв орлогоороо зарлагаа нөхдөг байх, үнийн хэт өсөлтийн шинжтэй баялгийн орлогыг хуримтлуулах, төсвийн алдагдлыг тэнцвэржүүлсэн орлогоор тооцоолж, алдагдал гарах бол түүнийг ДНБ-ий 2 хувиас, Засгийн газрын өрийн нийт үлдэгдлийг мөн ДНБ-ий 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар тогтоосон билээ. Энэ бол дэлхий нийтийн жишигтэй дүйцэж буй үзүүлэлт болохыг тайлант жилд хийсэн судалгааны үр дүн харуулсан болно.
- Европын Холбооны санхүүжилтээр Засгийн газар, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй Монголд засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд техникийн үйлчилгээ авч, манай улсын төсвийн хөндлөнгийн хяналт, шинжилгээний байдал болон ТТБЗ-ийн үйл ажиллагаанд энэ талаарх олон улсын шилдэг туршлагад үндэслэн үнэлгээ хийж, цаашдын чиглэлийг тогтоолоо. Тухайлбал, ТТБЗ-ийн эрх зүйн үндсийг хуулийн түвшинд хүргэх, чингэхдээ Сангийн яамтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах, хяналт үнэлгээний ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, төсвийн макро түвшний судалгааны чанарыг дээшлүүлэх, боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх зэрэг стратегийн зорилтыг тодорхойлсон. Тайлангийн жилд ТТБЗ, УИХ-ын холбогдох бүтцийн нэгжүүдийн төсөв, макро эдийн засгийн талаарх чадавхыг бэхжүүлэхэд илүүтэй анхаарал тавин ажиллалаа. Олон улсын практикт төсвийн институцийг хараат бус байдлаар ажиллуулахыг зөвлөдөг бөгөөд гагцхүү тэдний гаргасан санал, дүгнэлт үндэслэлтэй, бодитой, ойлгомжтой байх учиртай. Ийм чиглэл /хараат бусаар, үндэслэл, судалгаа сайтай санал, дүгнэлт гаргаж байх/-ээр ажиллахыг УИХ-ын Төсвийн байнгын хороо, түүний удирдлагаас дэмжинэ гэдгээ жилийн эхэнд бидэнд мэдэгдсэн юм.

- Монгол Улс тайлант 2021 оноос хойшхи оны төсөв дээр ачаалал өгөх арга хэмжээ, бодлогыг явуулах боломж хязгаарлагдсан болохыг Ковид-19 цар тахалтай байсан орнуудын төсвийн гүйцэтгэл харуулж буй бөгөөд нийгмийн зорилтот бүлэгт төсвийн хязгаарлагдмал нөөцийг зориулан хуваарилахаас өөр аргагүй байна гэсэн дүгнэлт хийлээ. Хүснэгт №1-ээс үзэхэд нэгдсэн төсвийн 2020, 2021 оны анхдагч болон тэнцвэржүүлсэн орлого нь урсгал зардлыг санхүүжүүлэхээс хэтрэхгүй болж, хөгжил, хөрөнгө оруулалтад зарцуулах төсвийн хөрөнгө хомс байжээ. Иймээс нийтийг хамарсан халамж, хөнгөлөлтөөс татгалзах шаардлагатай болохыг харуулсан жил байлаа. Энэ талын нийгмийн зөвшилцөл нааштай хандлагатай болж байна.
- Төсвийн гадуурх санхүүжилт 2020-2021 онуудад дахин газар авах шинжтэй болохыг төрийн түшээд, шийдвэр гаргагчдад танилцуулахыг ТТБЗ-өөс хичээж, төсөвт ирж болох эрсдэлийг цаг алдалгүй ил тод болгож, мэдээлж байхыг зорьж ажиллав.

ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТТБЗ 2021 онд нийтдээ 18 удаа хуралдаж, ажлын төлөвлөгөөнд туссан 50 орчим асуудлыг хэлэлцэж, санал, зөвлөмж гарган зөвлөлийн дүрэмд зааснаар хараат бус, бие даасан үнэлгээ, дүгнэлт гаргах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллалаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийн төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэлийн явц, макро эдийн засаг, санхүүгийн байдал, төсөвт нөлөө үзүүлэх эрх зүйн баримт бичгүүд зэрэгт санал дүгнэлт гаргах, мэдээ дохио өгөх зэрэг ажлыг ТТБЗ-ийн гишүүдийн хүчин чармайлт, УИХ-ын Тамгын газрын болон ТТБЗ-ийн ажлын албаны ажилтнуудын дэмжлэгтэйгээр явууллаа. УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дэмжлэг, тусламцааг авч ажиллахын зэрэгцээ тэдний чадавхыг бэхжүүлэх сургалтад хамруулах, ТТБЗ-ийн гишүүд өөрсдийн ажлын туршлага, мэдлэгийг тэдэнтэй хуваалцах, зааж чиглүүлэхийг хичээн ажилласан болно.

Нэрлэсэн ДНБ 2021 онд 43.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 14.9 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 27 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.4 хувиар тус тус өссөн мэдээ байна. Анхаарал татах зүйл бол ДНБ-ий оны үнээрх 15 орчим хувийн өсөлтөөс төсвийн орлого, зарлага илүүтэй нэмэгдсэн явдал юм. Үндэсний статистикийн хорооноос мэдээлснээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 14.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.8 (36.5 хувь) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 12.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 3.2 (34.1 хувь) их наяд төгрөгөөр нэмэгдэв. Нийт зарлага, эргэж төлөх цэвэр зээлийн хэмжээ 15.6 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл ДНБ-ий 6.8 хувь буюу 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарчээ. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.7 (12.2 хувь) их наяд төгрөгөөр нэмэгдэв. Зарлагын өсөлтөд урсгал зардал өмнөх оноос 1.9 (17.8 хувь) их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ. Энэ бол эдийн засгийн үр ашиг талаасаа сөрөг үр дагавартай болно.

Хөрөнгийн зардал 2021 онд 3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 12.7 (0.4 хувь) тэрбум төгрөгөөр нэмэгдсэнийг Үндэсний статистикийн хороо мэдээлэв.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт		2019 он	2020 он	2021 он	2022 он
		Гүйц.	Гүйц.	У.Гүйц	Тод.
1	Төсвийн нийт орлого	12040.3	10,444.2	14,255.2	16,278.1
2	Тэнцвэржүүлсэн нийт орлого	10,905.5	9,463.8	12,689.4	15,526.4
3	Төсвийн нийт зарлага	11,661.7	13,904.3	15,598.1	17,913.5
4	Урсгал зарлага	8,228.6	10,828.9	12,754.4	13,897.8
5	Хөрөнгийн зардал	3,016.7	3,034.2	3,047.0	4,280.3
6	Зээлийн үйлчилгээний төлбөр	860.9	939.20	827.7	909.0
7	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-756.2	-4,440.4	-2,908.8	-2,387.1
8	ДНБ-д эзлэх хувь	-2.0%	-12.0%	-6.8%	-5.1%

Эх үүсвэр: Сангийн яам

Дээрх хүснэгтээс үзэхэд сүүлийн хоёр жилд төсвийн урсгал зардал нь төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан байгаа бөгөөд түүнийг Ковид-19 цар тахлын хор уршгийг зөөлрүүлэх бодлого, арга хэмжээтэй холбон тайлбарлаж болох боловч алдагдлыг ДНБ-тэй харьцуулснаар дэндүү их буюу үндсэн суурь хязгаар 2 хувиас 5-10 хувь нэгжээр өндөр байна. Их зардал гаргасанд цар тахлын зэрэгцээ сонгуулийн нөлөө байгааг үгүйсгэхгүй байна. Гэхдээ тодорхой хэмжээний хязгаарын дотор алдагдлыг нэмэгдүүлэх эрх зүйн шаардлага тогтоож өгөх хэрэгтэй байна. Ялангуяа сонгуулийн жилд төсвийн зардал, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байхыг хуульчилбал зохино. Ийм шаардлага байгааг тайлангийн зураг №1-ээс харж болно.

Монгол түмэн баялгаасаа “хүртэх” ёстой гэсэн 2008 оны сонгуулиас эхлэлтэй ерөнхий ойлголт, сурталчилгааг нийгмийн зарим хэсэг буруу талаас нь хүлээн авч, **бэлэнчлэх сэтгэлгээнд дасаж, ажил хөдөлмөр эрхлэхэд хойрго хандах болсныг таслан зогсоох нь хамгийн том тулгамдсан асуудал болжээ** гэж дүгнэж байна. Үүнийг таслан зогсоож, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхгүй бол төсвийг эрүүлжүүлэх боломжгүйд хүрч байна. Баялгаа эрчимтэй ашиглах үед хуримтлал үүсгэх зорилготой байсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэрхэн өөрчилж ирснийг өнгөрсөн жилийн байдлаар гаргаж хавсаргав (**Хавсралт №1**).

УИХ-аас 2018 онд ТТБЗ-ийг байгуулахдаа дэвшүүлсэн эхний зорилт нь төсвийн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг мөрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэмээн тодорхойлсон байдаг.

1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр өгсөн санал, дүгнэлт

2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зорилт бол дээр дурдсанчлан нэгдсэн төсвийн балансжилтыг хангах, Засгийн газрын өрийг зохих түвшинд байлгахад дэмжлэг үзүүлж эрдэс, түүхий эдийн үнийн өсөлтийг дагуулан төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй байхаар хуульчилсан төсвийн тусгай шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөн ажиллах үндсэн дээр эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхэд оршиж байгаа билээ. Тус хууль 2010 оны 06 дугаар 24-нд батлагдсанаасаа хойш энэхүү тайлангийн 1-р хавсралтад дурдсанчлан нийтдээ 13 удаа нэмэлт, өөрчлөлт оржээ.


Хуулийн хэрэгжилт: Засгийн газар 2018, 2019 онд төсвийн тусгай шаардлагуудыг хангаж ажилласан боловч харамсалтай нь 2020, 2021 онд цар тахал, УИХ, орон нутаг болон Ерөнхийлөгчийн сонгуулийн нөлөөллөөс хамааран Монгол Улсын төсвийн алдагдал ихээхэн нэмэгдэж, 2021 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг нэмж үүнээс үүдэн гарах алдагдлыг нөхөхийн тулд мөн тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх өрийн дээд хэмжээг нэмэх болон хэрэгжих хугацааг хойшлуулах арга хэмжээ аваад байна. Ийм байдлыг дахин гаргуулахгүйгээр төсвийн шалгуур үзүүлэлтүүдийг буцаан хэвийн байдалд оруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах нь Төсвийн байнгын хорооны үндсэн зорилт бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэхэд ТТБЗ-ийн үйл ажиллагаа бүхэлдээ чиглэж байна.

Хуулийн өөрчлөлтүүдийн үр дагавар: Улсын төсвийн зарлага болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд сүүлийн жилүүдэд төсвийг алдагдалтай баталж ирсэн бөгөөд алдагдлын хэмжээг хязгаарласан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагуудыг түдгэлзүүлэх, хэрэгжих хугацааг хойшлуулах зэргээр алдагдлын болон өрийн хэмжээг улам нэмэгдүүлж байгаа нь төсвийн тогтвортой байдлыг алдагдуулахад нөлөөлж байна.

Монгол Улсын хувьд улсын төсвийн алдагдлыг дотоод, гадаадын өр болон тусламжаар санхүүжүүлсээр ирсэн бөгөөд төсвийн тогтвортой байдлыг хангах үүднээс өр болон ДНБ-ий харьцааны дээд хязгаарыг энэ хуулиар баталж, урт хугацаанд өрийг бууруулах стратеги баримталж байгаа боловч хуульд тусгагдсан өрийн дээд хязгаарыг удаа дараа төсөв болон төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх үеэр өөрчлөх нь эдийн засгийн тогтвортой байдалд ноцтой нөлөөлж байгаа хэлбэр юм. Иймд хуулийг байнга өөрчлөхгүйгээр урт хугацааны эдийн засгийн төлөвлөгөөг өрийн хязгаартаа тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх нь чухал.

Зөвлөлийн санал, дүгнэлт: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд төсвийн тусгай шаардлагыг 4 жил тутам хянан үзэж байх, эдийн засгийн өсөлт хасах болсон, томоохон гамшиг буюу өнөөгийн Ковид-19 цар тахлын хэмжээний зардалтай дүйцэхүйц гамшиг гарвал дээрх хоёр төсвийн тусгай шалгуурыг мөрдөхийг түр түдгэлзүүлэх хуулийн заалттай. Гэтэл энэхүү шалгуурыг өөрчилсөөр байгаа нь Үндсэн хуулийн нэгдүгээр зүйл дэх “хууль дээдлэх” зарчимд нийцэж буй эсэх, улмаар төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээ Засгийн газрын өрийн эрсдлийн судалгаагаар анхаарлын дээд түвшинд хүрчээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Энэ бүхэн цаашид Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд тусгагдсан төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилтод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах тухай асуудлыг хөндөн ярихад хүргэж мэдэхээр байна. Төсвийн алдагдал ДНБ-д харьцуулснаар хэрхэн өөрчлөгдсөнийг дараах зургаас харж болно.

Зураг 1. ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын динамик (хувиар)



Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн баримт бичиг

Төсөв, төлбөрийн тэнцлийн алдагдал эцсийн дүндээ улс орны өрийн хэмжээг нэмэгдүүлж байна. Засгийн газар өрийн эрсдлийн шинжилгээ хийж, анхаарах асуудлуудыг тодорхой гаргажээ. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны төсвийн баримт бичигт дурдсанаар “Засгийн газрын өр анхааруулах дээд түвшин буюу 45 хувиас давж, 93 хувь болсон байна” гэжээ. Өр нэмэгдэж буй гол шалтгаан бол төсвөөс гадна Монгол Улсын төлбөрийн урсгал тэнцэл олон жил алдагдалтай гарч, улмаар төсөвт ихээхэн ачаалал нэмэх хандлагатай болсонтой холбоотой. Урсгал данс ийнхүү алдагдалтай байгаа нь гадаадаас авах санхүүжилтийн хэрэгцээг үүсгэж байна.

2. Төсвөөс гадуурх санхүүжилтийн талаарх танилцуулга, зөвлөмж

ОУВС-тай Засгийн газар, Монголбанк 2017 оноос хамтарч хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилт”-ийн хөтөлбөрийн хүрээнд төсвийн сахилга батыг бэхжүүлж, төсвийг нэгдмэл болгон 2020 оныг хүртэл амжилттай хэрэгжүүлсэн юм. Гэвч 2020 оноос дэлхий дахинд, түүний дотор Монгол Улсад дэгдсэн Ковид-19 цар тахлын сөрөг үр дагаврыг хөнгөвчлөх болон сонгууль зэрэг улс төрийн шалтгааны улмаас Монгол Улсын төсөв ачааллаа даахгүй болж, төсвийн гадуурх санхүүжилт гаргаж, төсвийн хязгаарлалт, шалгуурыг тойрох явдал улам бүр газар авсаар байна. Ийм байдал гаргуулахгүй байх, түүнд судалгаа шинжилгээ хийж санал, дүгнэлт гаргаж байх үүргийг дээр дурдсанчлан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд УИХ-аас баталсан дүрэм, журмаар хүлээлгэсэн байдаг. Иймд “Төсвийн гадуурх санхүүжилтийг хязгаарлах шаардлагын тухай” Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн санал, зөвлөмжийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо, гишүүдэд хүргүүлсэн. Төсвийн гадуурх санхүүжилтийг хязгаарлах шаардлагын тухай танилцуулгыг хавсралт №2-д үзүүлэв. Уг танилцуулгад төсөв, санхүүгийн зардлын байдалд товч судалгаа хийж төсвийн гадуурх санхүүжилтийг хязгаарлах шаардлагатай болсныг тодорхой тусгасан. Мөн төсвийн алдагдал хийгээд төсвийн гадуурх аливаа зардал Монгол Улсын Засгийн газрын өрийг нэмэгдүүлж, ард түмний нуруун дээрх ачаалал ихэсч, улам бүр даахын аргагүй болгож байна. Иймд Засгийн газрын зүгээс гадаад зээл, бондын төлбөрийг хойшлуулж, хүүг нь бууруулж байгаа боловч хойшлуулсан буюу шинээр авсан зээлийн хүүний төлбөр улам бүр нэмэгдэж, нэг их наяд төгрөг рүү дөхөж байгааг шийдвэр гаргагчдад тооцоолон хүргүүлсэн. “Төсвийн гадуурх санхүүжилтийг хязгаарлах шаардлагын тухай” санал, зөвлөмжийн хэсгээс товч дурдвал:

- Төсвийн гадуур элдэв зардал гаргуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах, энэ чиглэлээр гарч байгаа санал, санаачилгыг дэмжихгүй байх, утга учир, хор холбогдлыг нь тайлбарлах зэрэгт чиглэсэн ажлыг УИХ-ын Байнгын хороод, Засгийн газраас зохион байгуулж байх;
- Монгол Улс гадаадаас зээл, тусламж авч төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд ашиглах явдлаас аль болох зайлсхийж улс орны хөгжлийг дэмжсэн Монголд үр өгөөжөө өгөх төсөл, хөтөлбөрүүдэд оруулах нь зүйтэй.
- Монголбанкны мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих мөнгөөр хангах жирийн арга хэмжээг нэмэгдүүлэхийг дэмжиж байна. Наад зах нь 6 хувь буюу бодлогын хүүтэйгээр эдийн засагт зээл гаргаж энэ хүүгээрээ Монголбанкинд ашиглагдаж байгаа зарим эх үүсвэрийн зардлыг нөхөхийг хичээх нь чухал. Тухайлбал, своп хэлцлийн хүрээнд жил бүр 400 орчим тэрбум төгрөгийг хүүд нь БНХАУ-д төлдөг. Ядахдаа энэхүү зардлыг нөхөх хэмжээний хүүтэй зээл олгох, хэрэв эх үүсвэрийн хүүнээс доогуур хүүтэй зээл олгох бол мөн төсвийн адил хэлэлцүүлэг хийж, хүүний зөрүүг нь төсвөөс төлөхөд хүрнэ гэдгийг ил болговол зохино.
- Төсөвт шууд болон цаашид дарамт учруулах санал, санаачлагыг хүлээн авахгүй байх. Төсвийн иж бүрэн байдлыг хангах, төсвийн гадуур зарлага гаргахыг зогсоох зэрэгт чиглэсэн тууштай бодлого явуулах, зайлшгүй арга хэмжээг цаг алдахгүйгээр зөвхөн төсвийн хүрээнд ил тодоор хэлэлцэн шийдэж байх, энэ талаар юуны түрүүнд УИХ, Засгийн газрын удирдлагын түвшинд сайтар авч үзэх, бодлогоо нэгтгэх нь чухал гэж үзэж байна.
- Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн Зөвлөл 2021 оны 5 дугаар сард төсвийн гадуурх санхүүжилтийн талаар хэлэлцүүлэг хийж, хураангуйлсан мэдээлэл ирүүлснийг эрхэм төрийн түшээдэд танилцуулах үүднээс тайланд хавсаргав (Хавсралт №3). Төсвийн гадуурх санхүүжилтийн эрх зүйн үндсийг тодорхой болгож, хязгаарлах, гарах эрсдэлээс хамгаалах, төсвийн иж бүрэн, ил тод байдлыг хангах, төсвийн төлөвлөлт тайлагналтад бүрэн хамруулах, төрийн өмчит компани, байгууллагуудын засаглалыг сайжруулах зэрэг тодорхой санал, дүгнэлт Нээлттэй нийгэм форумын танилцуулгад туссан болохын анхааралдаа авч ажил хэрэг болгохыг чухалчилж байна.

3. Төсвийн хүрээний мэдэгдэлд өгсөн санал, зөвлөмж

ТТБЗ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд 2021 оны 5 дугаар сарын 10-нд санал, дүгнэлт, зөвлөмжөө холбогдох танилцуулгын хамт хүргүүлсэн. Тухайн үед Засгийн газраас 2022 онд эдийн засаг хэвийн байдалд орж, 4.8 хувь хүрэх цаашдаа 6-аас доошгүй хувь хүрэх тооцоо ирүүлснийг хүлээн авч, төсвийн шалгуурыг мөрдөх нөхцөл бүрдлээ гэж үзэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг ДНБ-д харьцуулснаар 2022 онд 2 хувиар, цаашид 2023 онд 1.5, 2024 онд 1.0 болгон бууруулах санал тавьж, төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэх зөвлөмж өгсөн юм. Чингэхдээ төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд төсвийн тусгай шаардлагын үйлчлэлийг дараах тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно гэснийг үндэс болгосон болно. Үүнд: 8.1.1-д Тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь өмнөх жилтэй харьцуулахад “0”, эсхүл түүнээс бага, хасах хувьтай бол; 8.1.2-т Гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөлийн үр дагаврыг арилгахад төсвөөс нэмж шаардагдах санхүүжилтийн хэмжээ нь тухайн жилийн дотоодын нийт

бүтээгдэхүүний таван хувь ба түүнээс дээш хэмжээнд хүрэхээр бол; 8.2-т Үндэсний мөнгөн тэмдэгттэй харьцах гадаад валютын Монголбанкнаас зарласан тухайн оны эцсийн албан ханш нь өмнөх оны мөн үеийн албан ханшнаас 15 хувь ба түүнээс дээш хувиар өссөн тохиолдолд түр хугацаагаар түдгэлзүүлж болно. Дээрх 3 тохиолдол 2022 оноос арилах тооцоолол гарч буй учраас Төсвийн тогтвортой байдлын тухай 2010 оны хуулийн төсвийн тусгай шаардлагуудыг мөрдөж ажиллах нь зүйтэй гэж үзэж, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн төсөлд өгсөн зарим саналыг дахин танилцуулъя.

- Төсвийн тусгай шаардлагыг түдгэлзүүлэх нөхцөл үүссэн эсэхийг үл харгалзан төсвийн алдагдал, өрийг хязгаарласан шалгуур үзүүлэлтүүдийг хэд хэдэн жилийг хамруулан УИХ-аас өөрчилж ирсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг зөрчсөн үйлдэл гэж ТТБЗ үзэж, Төсвийн хүрээний мэдэгдлийг дагуулан төсвийн тусгай шаардлагыг хангуулах арга хэмжээ авахыг сануулсан. Төсвийн зардлын хэмжээ болон бүтцийг тодорхойлохдоо богино хугацааны макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, урт хугацааны үр ашгийг нэмэгдүүлэх зарчмыг баримталсны үндсэн дээр төсвийн ачааллыг дунд, урт хугацаанд бууруулах боломжийг сайтар судлахыг санал болгосон юм.
- Мөн төсвийн алдагдал, өрийн хэмжээг хязгаарлах зайлшгүй нөхцөл үүсээд байгааг танилцуулсан. Өр зээл өөрөө эдийн засгийг хязгаарлагч хүчин зүйл боллоо. Монгол Улсын, түүний дотор Засгийн газрын өр, ялангуяа гадаад өр төлбөрийн хэмжээ өссөөр байгаа байдалд шийдвэртэй дүгнэлт хийхгүй бол Улсын эдийн засаг үлэмж хүнд байдалд орох, төсөв алдагдалд хүрэх (зөвхөн зээлийн хүүд 2021-2024 онд жил бүр 1.1 их наяд төгрөг төлөх), Улсын эдийн засаг даахгүй болох эрсдэл холгүй байгааг онцгой анхаарах шаардлагатай байна. Монгол Улсын зээлийн үйлчилгээний зардал АХБ-ны тооцоогоор экспортын 50 хувь хүрээд байна. Өр зээл хэт нэмэгдсэнээс эдийн засаг, нийгмийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдаж, зээлийн хэмжээ эргээд төсөв, санхүүд сөрөг нөлөө үзүүлж байна. Засгийн газрын нийт өрийн доторх арилжааны шинжтэй зээлийн үлдэгдлээс тухайн төлөвлөгөөт жилд төлөгдөх хэсгийг бүгдийг нь дахин санхүүжүүлэх буюу шинэ зээлээр солих биш, ядахдаа 30 хүртэл хувийг тухайн онуудад төлөх зээлийн стратеги гаргаж мөрдөх нь зүйтэй. Энэ чиглэлээр 2020 онд гарсан нааштай алхмыг ойрын жилүүдэд улам лавшруулж хэрэгжүүлэх боломж гарна гэсэн төсөөлөл дэвшүүлжээ.
- Төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөхдөө эдийн засагт үзүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж, эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх, тэлэх төслүүдэд чиглүүлэх нь эргээд төсвийн тогтвортой байдалд эерэг нөлөөтэйг тооцож байх нь нэн чухал. Чингэхдээ төсөв болон төлбөрийн тэнцэлд нэгэн зэрэг эерэг нөлөө үзүүлэх төслүүдийг эхний ээлжид эрэмбэлэн хэрэгжүүлэх зарчим баримтлах хэрэгтэй болно.
- Төмөр зам, эрчим хүч, газрын тос боловсруулах үйлдвэр болон олон улсын стандартад нийцсэн экспортын үйлдвэрлэлийг төсөв, мөнгө зээлийн бодлогоор дэмжиж, энэ зориулалтаар гарах төсвийн зардлыг хязгаарлахгүй байх нь зүйтэй гэж үзлээ.

- Мөн газрын тос, зэсийн хайгуулыг дэмжих. Тухайлбал, хөрөнгө оруулагчдыг дээрх чиглэлээр хайгуул хийхийг бүх талаар дэмжих тухай тусгайлсан заалтыг УИХ-ын шийдвэрт тусгах.
- Монгол Улс ажил эрхлэлтийн түвшингээр бүс нутагтаа ихээхэн доогуур орсон байгаа тул бүтээмжтэй ажлын байр, хангалттай цалинтай нийгэм байгуулах үндсэн дээр эдийн засгийн, түүний дотор төсвийн тогтвортой байдлыг хангана гэсэн санааг байнга дэвшүүлж, сануулсаар байна. Монгол Улсад 15-аас дээш насны хөдөлмөрлөх боломжтой 1.9 сая иргэн байгаагийн 1.1 сая орчим нь хөдөлмөрлөж, түүний 0.7 сая орчим албан ёсны бүртгэлтэй, нийгмийн даатгалын шимтгэл, татвар төлж байна. Ажиллах хүчний оролцооны түвшин, даатгалын хамралт бусад зэрэгцүүлэх орнуудаас 20 гаруй нэгж хувиар доогуур байна. Иймд дунд хугацаандаа ажлын байр, үйлдвэржилт, бүтээн байгуулалтын ямар арга хэмжээ авах, даатгалын хамралтыг нэмэгдүүлэх хөшүүрэг хийгээд санхүүжилтийн эх үүсвэр, ажиллах хүчний бэлтгэлтэй холбосон иж бүрэн төлөвлөгөө хэрэгтэй болно. ТТБТ хууль ийм хөтөлбөртэй байхыг хуульчилсан байгаа. Ядахдаа эхний ээлжид ирэх 3 жилд сум бүрт 10 хүртэл хүнийг арьс, ноос, ноолуурын анхан шатны тордолт хийдэг чадавх суулгаж, худалдан авагчдын төлөөлөгчид, ченжүүдэд санал болгох, үйлдвэрүүдийн сургалтын хөтөлбөр, саналыг үндэслэн их дээд сургууль, коллежид суралцагсдын 10 хувийг мал аж ахуйн түүхий эдийн боловсруулах технологид сургах, инноваци, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, мэдээллийн технологийн чиглэлээр Улаанбаатар, Дархан, Эрдэнэтийн үйлдвэрлэлийн дэд бүтэц бүхий үйлдвэрлэл–технологийн бүсэд ажиллах инженер техникийн 200 хүртэл хүнийг гадаад, дотоодод суралцагсдаас шалгаруулж, сурган зах зээлд санал болгох, нөгөө талаас Эрдэнэт, Багануур, Оюутолгой, Тавантолгой зэрэг уул уурхайнуудад хагас, бэлэн бүтээгдэхүүний инженер, технологийн ажилтан бэлтгэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх санал тавьсан юм.

4. Монгол Улсын Хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд өгсөн санал, зөвлөмж

ТТБЗ нь Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний талаарх санал, зөвлөмжийг 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн. Санал, зөвлөмжийн хэсгээс дурдвал:

- Экспортынⁱⁱ үйлдвэрлэлийг дэмжих даатгал, зээлийн баталгаа, татвар, зээлийн хөнгөлөлт санхүүжилтийн хэрэгсэл зэргийг хамарсан иж бүрэн механизм бүрдүүлж хэрэгжүүлсэн байх (*Сангийн яам, Монголбанк, Гадаад харилцааны яам*).
- ОХУ тэргүүтэй Евро-Азийн Холбоо, түүний гишүүн орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээг дуусгаж байгуулсан байх (*Шадар сайд, Гадаад харилцааны яам*).
- Газрын тос дамжуулах хоолой барихыг хасаж оронд нь төмөр зам болгох. Учир нь Монголчууд өөрсдөө төмөр замаа 2-3 дахин хямд барьж чаддаг болсон, түүнд хэрэглэдэг цементээс эхлээд бараг бүх материал, хүн хүч Монголоос гаралтай нь цар тахлын өнөө үед дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний сүлжээг дэмжинэ. Төмөр зам бол мянганы бүтээн байгуулалт бөгөөд Дорнод зэрэг зүүн бүсэд малын өвс тэжээлээс эхлээд тээвэрлэх шаардлагатай шавхагдашгүй их баялаг бий төдийгүй байгалийн олон төрлийн баялаг бий. Зам дагаж хөгжил ирнэ, Чойбалсан хот төмөр замаар

Оростой холбогдсон байдгийг ч бодож, тэндээс Оросоос алсдаа түүхий газрын тос авна.

- Зэс, газрын тос, газрын ховор элемент, сэргээгдэх эрчим хүчний судалгаа, хайгуулыг нэмэгдүүлэхэд улсын болон хувийн хэвшлийн оролцоог хангаж, дэмжиж ажиллах. Үүнд зарцуулах хөрөнгийг 50-100 сая долларт хүргэх (Уул уурхайн сайд). Томоохон компаниуд хайгуулд багагүй мөнгө зарцуулдаг. Манай Эрдэнэт, Рио Тинто зэрэг компаниуд хайгуулыг эрчимжүүлэхэд бэлэн байгаагаа олон удаа хэвлэлээр зарласан. Үүнийг төрөөс дэмжих хэрэгтэй.
- Цахилгаан станц, цахилгааны сүлжээ, төмөр зам зэрэг томоохон бүтээн байгуулалтын санхүүжилтийг арилжааны банкууд өөр хоорондоо, эсвэл төртэй, компаниудтай хамтран бий болгож, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Монголбанк, Сангийн яаманд хариуцуулах.

5. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, санал

ТТБЗ 2022 оны нэгдсэн төсвийн төслийг нухацтай авч үзэж, өөрсдийн дүгнэлт, санал, зөвлөмжийг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр УИХ-ын Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн болно. Манай дүгнэлт, санал, зөвлөмжийг Төсвийн байнгын хороо хурлаараа авч хэлэлцсэн бөгөөд гишүүд ихээхэн ач холбогдол өгч, үнэтэй чиглэл зөвлөмж өгсөнд талархалтай байсан. Мөн УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдэд тэдний хүсэлтийн дагуу мэдээлэл хийсэн болно. Төсвийн байнгын хорооны дарга, гишүүдээс өгсөн чиглэлийн дагуу бид өөрсдийн дүгнэлт, санал, зөвлөмжийг Засгийн газар, Сангийн яаманд хүргүүлж, тэдний анхааралд оруулсан бөгөөд ажил хэрэгтээ хэрхэн тусгаж ажиллаж буй талаар анхааралтай ажиглалт явуулж байна. Мөн ТТБЗ бүрэн эрхийн дагуу олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгч, төсвийн хяналтыг хэрэгжүүлэхэд тэдний дэмжлэг авах чиглэлээр ажиллаж байна. 2022 оны төсвийн танилцуулгаас төрийн түшээдэд дахин танилцуулахад илүүдэхгүй гэж үзсэн зарим дүгнэлт, санал, зөвлөмжийн хэсгээс дурдвал:

- Төрөөс цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авах чадварыг хадгалах, ажлын байр, зээлийн бууралтыг сааруулах, хадгалах, улмаар нэмэгдүүлэх, эрүүл мэнд, нийгмийн халамжаас бусад төсвийн зардалд хэмнэлтийн горим тогтоох, халамжийг эрс багасгаж, ажлын байр, нийгмийн эмзэг хэсгийг хамгаалах чиглэлээр тууштай ажиллах явдал юм. Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр шатахуун, гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, ном хэвлэл худалдан авах, хэвлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, байгууллага салбарын ой тэмдэглэх, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, кино уран бүтээл хийх, шинээр автомашин худалдан авах зардлыг хязгаарлахаар төлөвлөснийг дэмжсэн.
- Нэгдсэн төсвийн урсгал зардлын 30.6 хувь буюу 4,065.7 тэрбум төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд, 62.2 хувь буюу 8,282.3 тэрбум төгрөгийг татаас ба урсгал шилжүүлэгт, 7.2 хувь буюу 959.3 тэрбум төгрөгийг зээлийн үйлчилгээний төлбөрт зарцуулахаар төсвийн төсөлд тусгажээ. Дээрх 4,065.7 тэрбум гаруй төгрөгийн бараа, үйлчилгээний ихэнхийг цар тахлын үед голчлон эх орныхоо аж ахуйн газруудаас худалдан авах зорилт тавьж, нарийвчилсан судалгаа хийхийг Засгийн газар, бүх шатны засаг захиргааны байгууллагуудад санал болгосон.

- Уул уурхайн орлого өссөн он жилүүдэд цалин нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг багасгах, дэд бүтэц, нийгмийн чиглэлтэй төсөл, хөтөлбөрүүд багагүй хэрэгжсэн ч хавтгайрсан бэлэн мөнгөний олголт 2008 оноос нэмэгдэж, ямар нэг хэмжээгээр өнөөг хүртэл үргэлжилсэн хэвээр байна. Харин Засгийн газраас 2022 оноос эхлэн хавтгайрсан халамж тэтгэлгийг хязгаарлаж, зорилтот бүлэгт чиглүүлэх, ажлын байр, хуримтлал бий болгох, хөрөнгө оруулалтад илүү анхаарах зорилт тавьж байгааг дэмжиж байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтыг улсынхаа эдийн засагт оруулах ач холбогдлоор эрэмбэлж, эдийн засгийг тэлэх, төсвийн орлогыг нэмэгдүүлэх, экспортыг өсгөх төсөлд чиглүүлсэн гэх боловч чухам хэдэн төсөл, яаж нөлөөлөх талаар тодорхой судалгаа харагдахгүй байна. 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд томоохон объект, үйлдвэрлэл, экспортын бүтээгдэхүүнийг дэмжсэн төсөл харагдахгүй байна. Хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргасан байхыг шаарддаг боловч энэ төрлийн тооцоо, дүгнэлт байхгүй байгааг цаашид онцгой анхаарч хуулийн заалтыг мөрдөж, ийм үйлдэл гаргахгүй байх нь зүйтэй.
- Дэлхий дахинаа 2021 он гарсаар зэс, төмрийн хүдрийн үнэ өссөн бол коксжих нүүрсний үнэ тогтвортой байгаа нь Монгол Улсын эдийн засаг сэргэх, төсвийн орлогын төлөвлөгөө биелэх суурь боломжийг хангаж байв. Гэхдээ дэлхийн зах зээл дээр нүүрс, алт, зэс, төмрийн хүдрийн үнийн төсөвт авсан төсөөллөөс үнэ буурвал орлогын эрсдэл үүснэ. Үүний зэрэгцээ манай орны нүүрсний гол хэрэглэгч болох БНХАУ нүүрсний олон нийлүүлэгчтэй болсны зэрэгцээ хэрэглээг багасгах зорилт дэвшүүлээд байгааг анхаарч үзэх ёстой. Үүний зэрэгцээ экспортын бүтээгдэхүүнээ гаргах боомтуудын үйл ажиллагаа тогтворжоогүй, дэд бүтэц сул байгаа нь тавьсан зорилтоо хэрэгжүүлэх боломжид эрсдэл үүсгэхээр байгаа юм. Урд хөрш рүү гаргах нүүрсний тээврийн вагоны зам тавигдаж байгаа боловч хилээр хэрхэн нэвтрүүлэх талаар Засгийн газар тодорхой шийдэлд хүрэхгүй байгаа нь эрсдэл үүсэх бас нэг нөхцөл болж байна.
- Манай орны эдийн засагт учирч буй хамгийн том дарамт бол улсын өр юм. Ийм учраас Сангийн яам, Монголбанк 2022 онд төлөгдөх 1 тэрбум ам.долларын үнийн дүнтэй, 5.125 хувийн хүүтэй Чингис бондын үлдэгдэл 799 сая ам.долларыг бүрэн хэмжээгээр, 2023 онд төлөгдөх 5.625 хувийн хүүтэй 800 сая ам.долларын үнийн дүнтэй Гэрэгэ бондоос 200 сая ам.долларыг 1 тэрбум ам.долларын “Сенчюри” бонд (6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500.0 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.доллар)-ын зээллэгээр солих ажлыг зохион байгуулж, өрийн дарамтыг хойшлуулсан байна. Дэлхий дахинд бондын хүү нэмэгдэх нөхцөл үүсэж болохыг сүүлийн үед мэдээлэх болсон нь цаг хожсон бөгөөд хүүний хэмжээг 1.5 гаруй нэгж хувиар буулгасан байна.
- Урсгал төлбөрийн тэнцлийн динамикаас үзэхэд 2008 оноос хойш жил бүр алдагдалтай гарч байсны дотор уул уурхайн бүтээн байгуулалт ид өрнөсөн 2011- 2013 онд урсгал тэнцлийн алдагдал 4-5 тэрбум ам.доллар хүрч байжээ. Үүнийг хавсралт хүснэгт №2а-оос дэлгэрүүлэн үзнэ үү. Энэ бол манай улсад үйлдвэрлэлийн бааз, мэргэжлийн ажиллах хүчний нөөц байхгүй, гадаадаас авсан зээл, хөрөнгө оруулалт эргээд импортын болон гадаадын мэргэжилтэн, ажилчдын төлбөрт шууд зориулагдаж байсныг гэрчилж байна. Нөгөө талаас урсгал төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаа нь Монгол Улсыг өрийн дарамтад оруулж байна. Жишээлбэл, 2010-2020 онд урсгал дансны алдагдал

жилд дунджаар 2,299.0 ам.доллар болж, энэ хугацааны нийт алдагдлын дүн 25.3 тэрбум ам.долларт хүрч, 2020 оны эцсийн байдлаарх өрийн үлдэгдэл болох 32.4 тэрбум ам.долларын 78 хувийг эзэлж байна. Төлбөрийн тэнцэл төсөвт шууд нөлөөтэй асуудлыг эхлэн шийдэж чадахгүй явж ирснийг зарим тоо баримт гэрчилж байгаа юм. Жишээ нь: Монгол Улс жил бүр 140 орчим сая ам.долларын цахилгаан импортолж байна. Үүний дотор БНХАУ-аас 110 орчим сая ам.долларын цахилгаан авч, нүүрсээ машинаар тээвэрлэж, жил бүр 500.0 орчим сая ам.долларыг Тавантолгойгоос хил хүртэл тээврийн төлбөрт төлж байгаа зэрэг нь татвар ногдох орлогыг бууруулж байна. Энэ нь цахилгаан станц, төмөр зам барих ажлыг улам эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна. Төмөр замаар нэг тонн нүүрсийг 9 ам.доллаароор тээвэрлэх, автомашинаар 34 ам.долларын өртөгтэйгөөр зөөхийн зөрүү 25 ам.доллар, Гашуун Сухайтаар 20 орчим сая тонн нүүрс гаргана гэж тооцоход дээрх алдагдал гарч байгаа юм. Манай улс 2010 онд 286.4 мянган тонн бензинийг 230.2 сая ам.доллаароор, дизелийн түлш 502.2 мянган тонныг 400.0 сая ам.доллар, нийтдээ 630.2 сая ам.доллар төлж байсан бол 2020 онд 586.1 мянган тонн бензинийг 244.7 сая ам.доллаароор, дизелийн түлш 1,026.9 мянган тонныг 432.4 сая ам.доллаароор, нийтдээ 681.1 сая ам.доллар төлж импортолсон байна. Энэ тоо үнийн дүнгийн хувьд нэг тэрбумаар нэмэгдэх нөхцөл бүрдэх эрсдэл нүүрлэж байна. Сүүлийн 11 жилд үүсэж буй урсгал тэнцлийн алдагдлын 25.3 тэрбум ам.долларын 53 хувь буюу 13.4 тэрбум ам.доллар нь үйлчилгээний худалдааны алдагдал, 12.5 тэрбум ам.доллар буюу 49.4 хувийг анхдагч орлогын алдагдал бүрдүүлж байна. Харин хоёрдогч орлогын цэвэр нэмэх зөрүү болох 2.4 тэрбум ам.доллар нь буцалтгүй тусламж бөгөөд урсгал зардлын алдагдлыг нөхөх нөлөөтэй. Анхаарал татаж буй асуудал бол техник туслалцааны шинжтэй, хамгийн их алдагдалтай бизнес үйлчилгээ, үүний дараа тээвэр, аялал жуулчлал, барилгын үйлчилгээ, харилцаа холбоо орж байгаа явдал юм. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгт 26-аас харж болно.

Хүснэгт 26. Төлбөрийн тэнцэл (Сая ам.доллар)

Үзүүлэлт	Дундаж (2010-2020)	Нийт (2010-2020)	2021
1.А.б Үйлчилгээ	-1,261	-13,866	-726
1.А.б.1 Бусдын эзэмшлийн бүтээгдэхүүнд нэмэлт боловсруулалт хийх үйлчилгээ	-1	-8	2
1.А.б.2 Засварлалт болон угсралтын үйлчилгээ	-6	-68	0
1.А.б.3 Тээвэр	-280	-3,085	-9
1.А.б.4 Аялал жуулчлал	-276	-3,037	-342
1.А.б.5 Барилга, барилгын ажил үйлчилгээ	-160	-1,764	-63
1.А.б.6 Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ	-19	-210	-10
1.А.б.7 Санхүүгийн үйлчилгээ	-86	-947	-34
1.А.б.9 Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ	-63	-693	-68
1.А.б.10 Бизнесийн бусад үйлчилгээ	-337	-3,705	-169
1.А.б.11 Хувийн, соёлын, амралт чөлөөт цагийн үйлчилгээ	0	-4	0
1.А.б.12 Засгийн газрын бараа, үйлчилгээ	-17	-192	-14

Эх сурвалж: Монголбанк

- Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга батыг бэхжүүлэх, далд орлогыг илрүүлэхэд татварын бүртгэл, түүнийг нийгмийн халамжтай холбох нь чухал болно. Төсвөөс иргэд, түүний дотор хүүхдүүдэд олгож буй аливаа тусламж тэтгэлэг, нөхөн олговрыг тухайн иргэн, тэдний гэр бүлийн орлого, татварын төлөлттэй төдийлөн холбогдохгүй байгаа юм. Олон улсын шилдэг туршлага бол төрөөс олгох аливаа дэмжлэг, туслалцаа нь татварын тайлангаар голчлон тодорхойлогддог байна. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 25.2-д хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэж татвар

төлөгчийн дугаар олгоно (иргэн) гэсэн зохицуулалтыг тусгасан. НӨАТ-ын хуулийн дагуу и-баримтын системд 2,063,608 иргэн бүртгэлтэй байна. ТЕГ-ын 2020 оны мэдээллээр ХХОАТ-ын хуулийн Цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого (ТТ-11)-оор 675,134 иргэнээс суутгаснаар татвар ногдуулсан тайланг ирүүлсэн байна. Үйл ажиллагааны орлого олж буй 181,606 иргэн бүртгэлтэй боловч 21,489 иргэн нь тайлан ирүүлсэн байна. ТТ-11, ТТ-06 гэсэн тайланг ирүүлсэн 51,401 татвар төлөгч иргэн ХХОАТ-ын хуулийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлт (орон сууцны, сургалтын төлбөрийн хөнгөлөлт) эдэлжээ. Татвар төлөгч иргэний бүртгэлийн дугаар нь хуульд заасан нэгдсэн дугаарт одоогоор шилжээгүй байна. Өнөөгийн байдлаар иргэний хувьд иргэний бүртгэлийн регистрийн дугаар, татвар төлөгчийн дугаар, нийгмийн даатгалын дэвтрийн дугаар гэсэн тус тусын дугаартай байгаа нь иргэний мэдээлэл бүртгэлийн нэгдмэл байдалд ороогүй байгаа ба татвар төлөх үүргийн биелэлт, нийгмийн халамж нь харилцан уялдаагүй явагдаж байгааг харуулна. Үүнийг цаашдаа нэгдсэн бүртгэлд оруулж, иргэдийн орлого, татварын тайлантай халамж, тэтгэлэг, хөнгөлөлтүүдийг холбох нь чухал болно.

- Татварын ерөнхий болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу сум, дүүрэгт хүн амын орлогын татвар 100 хувь, аж ахуйн нэгжийн орлогын татварын 40 хувь орох болсныг орон нутгийн бүх шатны удирдлага ашиглаж, орлого нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох ажилд томоохон ахиц гаргах хүлээлт байна.

6. Цаг үеийн зарим асуудлын талаар:

- ТТБЗ-ийн гишүүн Л.Отгонтуяа УИХ-ын Төсвийн байнгын хорооноос Монгол улсын сүүлийн 15 жилийн төсвийн байдалд судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт өгөх дэд ажлын хэсэгт ажиллан “Монгол Улсад 2006-2020 онд хэрэгжүүлсэн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд хийсэн дүн шинжилгээ, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар гаргасан санал, дүгнэлт”-ийн агуулгыг боловсруулж, үндсэн ажлын хэсгийн болон дэд ажлын хэсгийн хуралд оролцож өөрийн саналыг хэлж, санал солилцсон. Мөн Төрийн албан хаагчдад зориулсан “Алсын хараа-2050” бодлогын талаар Удирдлагын академийн цахим сургалтад болон аймаг, сумдын ИТХ-ын Төлөөлөгчдөд зориулсан сургалт, уулзалтын үеэр ТТБТ хуулийн тусгай шаардлага, ТТБЗ-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар байнга мэдээлэл өгөн ажиллаж байна.
- ТТБЗ-ийн захиалгаар орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, хүн амд төрөөс үзүүлж байгаа нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулахад чиглэгдсэн “Орон нутгийн бие даасан байдлыг хангах нь” судалгааны ажлыг хийж гүйцэтгүүлсэн.
- ТТБЗ-ийн гишүүн Г.Алтанзаяа “Татварын боловсрол төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх нь” судалгааны тайлан ба дагалдах ЭЗХАХБ (OECD)-аас 29 улсын туршлагаар хийгдсэн судалгааг хийж танилцуулсан. Мөн хувь хүнийг татвар төлөгчөөр бүртгэж татвар төлөгчийн дугаар олгох болон иргэний нийгмийн даатгалд хамрагдалт, иргэний үүргийн хүрээний мэдээллийг судалсан.

- ТТБЗ-ийн гишүүн Д.Сувдаа Засаг захиргааны нэгж, нутгийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой 2022 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн төсвийн тогтвортой байдлыг хангахад нөлөөлж буй хууль, эрхзүйн орчны нөлөөлийн талаар судалгааны ажил хийсэн. Мөн “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хэрэгжилтэд санал, дүгнэлт өгсөн.
- ТТБЗ-ийн гишүүн Э.Бямбажав Тэтгэврийн зээлийг тэглэх талаарх УИХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, төсвийн гадуурх зарлагын талаар анхаарах асуудлын санал, дүгнэлт болон Оюутолгой төсөлтэй холбогдсон гэрээний хэрэгжилтийн талаар судалгаа хийж, саналаа бичиж холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хэвлэлд нийтэлсэн. Мөн макро эдийн засгийн голлох салбарууд, гадаад, дотоодын санхүүгийн секторын төлөв байдлын төсөөллийн загварын талаар судалгаа, санал болон Хараат бус баялгийн сангийн талаар 40 гаруй орны 70 гаруй сангийн талаар судалгаа хийж, танилцуулга бэлтгэсэн.
- “Газрын тосны үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл”-д газрын тосны экспортын тоо хэмжээ, үнэ, бензин, дизель түлшний импортын хэмжээ, онцгой албан татварын хэмжээг сүүлийн 15 жилээр гаргаж санал хүргүүлсэн.
- Дэлхийн банкны “Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Дэлхийн банк, Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн нэгжтэй тогтмол харилцан ажилласан. Тус төслийн хүрээнд “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх” зорилгоор дотоодын хоёр зөвлөх, гадаадын нэг зөвлөхтэй гэрээ байгуулан ажлын даалгавар, төлөвлөгөөний дагуу ажилласан болно.

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА

ТТБЗ нь Олон улсын валютын сан, Дэлхийн банкны хамтын ажиллагааны хүрээнд төсвийн хөндлөнгийн хяналт, шинжилгээний асуудлаар хүлээн зөвшөөрөгдсөн Австрали улсын иргэн Паул Гарднертэй 3 сарын гэрээ байгуулж, энэхүү хугацааны турш цахим уулзалт, ярилцлага тогтмол хийж, и-мэйлээр өдөр бүр харилцаж, түүний туршлага, мэдлэг боловсролыг бүрэн ашиглахыг хичээн ажилласан болно. Ноён Гарднерийн хүсэлтийн дагуу Монгол Улсын төсөв, санхүүтэй холбогдсон хууль эрх зүйн баримт бичгүүд, ТТБЗ-ийн байгуулагдсан цагаас хойшхи хийж гүйцэтгэсэн тайлан, төсвийн талаарх санал дүгнэлтүүд, ДНБ, ажил эрхлэлт, төсөв, санхүү, эдийн засгийн зэрэг тоо баримтуудыг сүүлийн 30 жилийн байдлаар гаргаж танилцуулсан. Гадаад зөвлөх өөрийн зүгээс олон асуулт, тодруулга ирүүлж, ТТБЗ-ийн дарга гишүүд, Сангийн яам, Монголбанк, эдийн засгийн хөгжлийн агентлаг, УИХ-ын ТБХ-ны дэргэдэх төсвийн шинжилгээний холбогдох ажилтнуудаас асуулт тодруулж авч, цахим уулзалтууд хийх ажлыг зохион байгуулсан. Тус гадаад зөвлөхийн ажлын эцсийн тайланг УИХ-ын ТБХ-ны гишүүдэд дахин тусгайлан хүргүүлсэн. Уг тайланд ТТБЗ-ийн ажлын өнөөгийн түвшин, цаашид хийх ажил, Монгол Улс төсвийн дүрмээ хэрхэн мөрдөж ажилласан, уул уурхайн орлогоо хэрхэн оновчтой ашиглах талаар үнэтэй санал, зөвлөмж өгсөн нь ТТБЗ-ийн дунд хугацааны ажлын баримт бичиг болж байна. Түүний тайлангаас дүгнэлт, зөвлөмжийн хэсгийг 2021 оны энэхүү тайланд дор дурдсанаар оруулж байна. Үүнд:

ТТБЗ-ийн бүрэн эрхийн тухайд:

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн өнөөгийн бүрэн эрх нь өргөн цар хүрээг хамарсан тул тус зөвлөл өөрөө чухал гэж үзсэн төсөв, санхүүгийн аливаа асуудал дээр ажиллах бүрэн боломжтой байна. Гэхдээ одоохондоо хөгжлийн эхний шатанд ТТБЗ нь бүрэн эрхээ илүүтэй зорилтот болгон тодорхой бүтээгдэхүүн, төсвийн мөчлөгт оролцох асуудлуудад өөрийн хүч нөлөөг төвлөрүүлэх нь оновчтой байхаар байна. Засгийн газрын төсвийн стратеги нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тодорхойлсончлон макро эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдсэн байна. Төсвийн стратегийг онцлон авч үздэг Засгийн газрын эдийн засаг, төсвийн төсөөлөл нь ил тод, үнэн зөв, намч бус байх хийгээд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудад нийцсэн байх ёстой. Гэвч Засгийн газрын сүүлийн арван жилийн төсвийн стратеги нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй байжээ. Өнөөгийн төсвийн хүрээний тогтолцоонд Засгийн газрын эдийн засаг, төсвийн төсөөлөлд намч бус, бие даасан үнэлэлт, дүгнэлт өгөх, төсвийн тусгай шаардлагын нийцлийг үнэлэх ажлыг эрх бүхий байгууллага (ТТБЗ)-аар хийлгэх ажилд илэрхий дутагдал байна. Ийм үүргийг ТТБЗ-д ногдуулах нь гадаадын бие даасан төсвийн институтүүдийн нийтлэг практик юм. Цаашид анхаарах бас нэг зүйл бол Монгол улсын төсвийн орлогын бааз суурь тогтворгүй, нийт орлогын 30 орчим хувь нь өндөр эрсдэл бүхий эрдэс, түүхий эдийн эх үүсвэрээс бүрдэж байна. Энэ нь нэгдсэн төсвийн орлогын төсөөлөлд ихээхэн эрсдэл учруулж байна. Түүнчлэн, Монгол Улсын төсвийн зарлага нь орлогоосоо, ялангуяа сонгуулийн жилүүдэд байнга хэтэрч, зардлын гүйцэтгэл дээр тогтворгүй орчин бүрдүүлж байна. Дахин сануулахад зарлагадаад байх сонирхол бүхий зан төрх нэгдсэн төсвийн зарлагын төсөөлөлд нилээдгүй эрсдэл учруулж байна. Эдгээр эрсдэлийг ил гаргаж, тооцоолол хийж, улмаар төсвийн төсөөлөл, Засгийн газрын шийдвэрүүдийн үр нөлөөг илүүтэй ил тод болгон, улмаар төсвийн засаглалыг сайжруулахад туслах явдал нь ТТБЗ-ийн бас нэгэн үүрэг юм. Засгийн газрын зардлын талаар ТТБЗ өөрөө төсөөлөл хийх нь их хэмжээний үнэ цэнэ бий болгож чадахгүй ч гэсэн Засгийн газрын зардлыг нэмэгдүүлж ирсэн болон цаашид нэмэгдүүлэх хүчин зүйлүүдэд нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийж УИХ-ын гишүүд, олон нийтэд мэдээлэн улмаар хэвлэн нийтэлж түгээх нь үнэ цэн нэмэх зүйл болно.

Гадаадын зөвлөхийн зөвлөмжүүд:

Зөвлөмж 1: Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ТТБЗ-ийг Монгол Улсын төсвийн хүрээ, тогтолцоо, стратегийн нэгэн гол бүрэлдэхүүн байгууллага гэж хүлээн зөвшөөрүүлж хуульчлах ёстой. Эдгээр 2 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Засгийн газрын эдийн засаг, төсвийн төсөөлөлд үнэлэлт, дүгнэлт өгөх үүргээ ТТБЗ биелүүлэх боломж бүрдэх юм.

Зөвлөмж 2: 2022 оноос эхлэн ТТБЗ нь Засгийн газрын эдийн засаг, төсвийн төсөөллийн үнэлгээг хийж эхлэх хэрэгтэй. Энэхүү эхний үнэлгээг 2023 оны Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн эдийн засаг, төсвийн төсөөлөлд хийх бөгөөд ялангуяа түүний орлогын төсөөлөлд онцгой анхаарал хандуулж, орлогын төсөөлөлд учирч болзошгүй эрсдэлийг тоон үзүүлэлтээр тооцож, үнэлэх шаардлагатай. Энэхүү үнэлгээний тайланг УИХ-д өргөн мэдүүлж, ТТБЗ-ийн вэбсайтад хэвлэн нийтлэх ёстой.

Зөвлөмж 3: 2021 онд багтаан Засгийн газрын өнгөрсөн түүхэн үеийн болон ирээдүйн зардлын гол хүчин зүйлсийн судалгааны (салбараар болон чиг үүргээр) тайлан гаргах.

Зөвлөмж 4: ТТБЗ нь шинжилгээний нэгжээ наад зах нь 5 үндсэн ажилтантай болгохыг эрэлхийлэх хэрэгтэй. Эдгээр ажилтны 2 нь макро эдийн засаг, төсвийн төсөөлөл боловсруулж байсан өндөр түвшний туршлагатай байх ёстой.

Зөвлөмж 5: Сангийн яам, Монголбанк болон төрийн бусад байгууллагын туршлагатай ажилтнуудыг ТТБЗ-д хавсран ажиллуулах сонголтыг идэвхтэй хэрэгжүүлэх хэрэгтэй.

Зөвлөмж 6: ТТБЗ-ийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааг удирдах үүргийн хүрээнд ТТБЗ-ийн ажилтнуудыг ажилд авахыг хариуцдаг байвал зохино. ТТБЗ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар, зааварчлагыг бий болгож, ажилтнууддаа эзэмшүүлэх шаардлагатай. ТТБЗ нь 1-2 орон тооны туршлага, ур чадвартай мэргэжилтнийг тогтвортой ажиллуулахын зэрэгцээ бусад хэд хэдэн ажилтныг нэмж авч ажиллуулбал ахлах ажилтан нь шинэ залуу боловсон хүчний мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд тустай байх болно. ТТБЗ одоогийн байдлаар санхүүгийн програмчлал, макро эдийн засгийн данс тооцоолол, төсөөллийн аргачлалын үндсэн ойлголтуудын талаарх сургалтад хамрагдаж, суралцах хүсэл эрмэлзийг ТТБЗ-ийн гишүүд болон Төсвийн шинжилгээний нэгжийн ажилтнуудад бий болгосон байна. Цаашид шинэ залуу боловсон хүчнийг ажилд авах, шаардлагатай мэдээлэл олж авах, төсөөллийн загвар боловсруулах зэрэг ажлуудыг ирээдүйн сургалт, чадавхыг бэхжүүлэх ажлуудтай уялдуулан зохицуулж байх нь чухал. ТТБЗ нь мөн ийм төрлийн мэргэжлийн сургалтын чанартай үйлчилгээ үзүүлдэг өндөр чадавхтай байгууллагыг олж, хамтран ажиллах шаардлагатай.

Зөвлөмж 7: ТТБЗ-ийн гишүүд, ажилтнуудад макро эдийн засаг, төсвийн төсөөлөл, дүн шинжилгээ хийх арга, техникийг эзэмшүүлэх, чадавхыг хөгжүүлэх боломжуудыг үргэлжлүүлэн эрэлхийлэх шаардлагатай. Эхний ээлжид Сангийн яамны мэргэжилтнүүдээр макро эдийн засгийн төсөөлөл, орлого, зардлын болон өрийн төсөөлөл, мөн өрийн тогтвортой байдлын шинжилгээний хүрээний аргачлал, хандлагын талаар цуврал семинар, сургалт хийлгэх нь үр дүнтэй байх болно.

Зөвлөмж 8: Макро эдийн засаг, төсвийн шинжилгээ хийх чиглэлд ТТБЗ-ийн чадавхыг цаашид хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор Дэлхийн банк, ОУВС болон ЭЗХАХБ-аас санал болгож буй боломжуудыг үргэлжлүүлэн ашиглах хэрэгтэй.

Зөвлөмж 9: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд ТТБЗ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх мэдээллийг төрийн байгууллагуудаас шууд авах боломжтой байх заалтыг нэмэлтээр тусгаж оруулах.

Мэдээлэл олж авах боломж: Эдийн засаг, төсвийн дэлгэрэнгүй нарийвчилсан мэдээллийг олж авах нь ТТБЗ өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хамгийн чухал ач холбогдолтой. Үүнийг хууль тогтоомжид тусгахын зэрэгцээ ТТБЗ болон Засгийн газрын холбогдох байгууллагуудын хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ээр дамжуулан хэрэгжүүлж болно. ТТБЗ нь одоогоор Сангийн яам, Монголбанктай хамтран ажиллах Санамж бичгүүд байгуулжээ. Мэдээлэл олж авах, туршлага, мэдлэг, шинжилгээний ажлаа харилцан уялдуулах талаар Санамж бичгүүдийн ерөнхий агуулга боломжийн түвшинд тодорхойлогджээ. Ийм ажил хэргийн харилцаа, хамтын ажиллагаа нь нэн ялангуяа ТТБЗ -ийн ажилтнуудын шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Бүрэн

эрхээ тодорхой болгон шинэчлэх ажлын хүрээнд илүү тодорхой мэдээлэл, тухайлбал, ТТБЗ-өөс УИХ-д тайлагнах үүргийн дагуу хүргүүлэх материалуудын шаардлагыг хангах хэмжээний макро эдийн засаг, төсвийн төсөөллийн хамгийн сүүлийн үеийн илүү дэлгэрэнгүй мэдээллийг тохиролцсон хугацаанд авч байхаар тооцож, холбогдох санамж бичгүүдийг шинэчлэх хэрэгтэй болно. Өөр нэг зүйл бол санамж бичгүүдэд мэдээлэл өгөхөөс татгалзах, эсвэл мэдээлэл нь ТТБЗ -ээс тогтоосон цаг хугацаандаа ирэхгүй байх тохиолдлуудыг зохицуулсан ямар нэг механизм байхгүй байна. Мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдлыг нийтэд мэдээлэх (жишээ нь Португалийн Санхүүгийн Зөвлөл) эсвэл мэдээлэл авах хүсэлтийн цаг хугацааны тухай статистикийг тогтмол тайлагнах (жишээ нь Австралийн Парламентийн Төсвийн Алба гэх мэт) гэх мэт механизмууд нь мэдээллийг цаг тухайд нь хүлээж авч байхад тустай байж болох юм. Шаардлагатай тохиолдолд Монголын Гаалийн Ерөнхий Газар, Монголын Татварын Газар зэрэг бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл олж авах сувгийг хөгжүүлэх шаардлагатай.

Зөвлөмж 10: Одоогийн Санамж бичгүүдийг шинэчлэн боловсруулж, ТТБЗ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай мэдээлэл, түүнийг хүргүүлэх эцсийн хугацааг тусгаж өгөх.

Зөвлөмж 11: Бусад холбогдох төрийн байгууллагуудтай Санамж бичгүүд байгуулах. ТТБЗ өөрийн үйл ажиллагаагаараа ил тод байдлыг идэвхтэй дэмжиж ажиллах шаардлагатай. ТТБЗ хийсэн бүх шинжилгээгээ УИХ-д хүргүүлж өөрийн шинэ вебсайт дээр хэвлэн нийтэлж байх хэрэгтэй. Үүнд, ил тод байдлыг бүрэн хангах, ТТБЗ-ийн итгэл хүлээх байдлыг бэхжүүлэх зорилгоор ТТБЗ-ийн тайлан, суурь тоо мэдээллүүд, шинжилгээний аргачлалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаана. Вебсайт нь стратеги төлөвлөгөө, жилийн ажлын төлөвлөгөө, гишүүдийн танилцуулга гэх мэт байгууллагын бүх тайлан, мэдээг агуулсан байна. ТТБЗ нь өөрийн нөлөө, нөлөөллийг тооцох хэмжигдэхүүнийг боловсруулж хянах байх ёстой.

Зөвлөмж 12: УИХ-ын гишүүд, эцсийн үнэлгээ өгөх чадвартай судлаачид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг бусад оролцогч талуудыг ТТБЗ -ийн шинжилгээний ажилд анхаарал хандуулж, оролцоог хангахыг эрэлхийлэх, мөн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлж хэмжих тогтолцоог боловсруулах шаардлагатай.

2021 онд:

- Судалгаа, шинжилгээний ажилтнуудыг нэмж сонгон шалгаруулж авч дуусгах;
- Одоо байгаа санамж бичгүүдийг шинэчилж дуусгах, холбогдох бусад төрийн байгууллагуудтай санамж бичгүүд шинээр байгуулж дуусгах;
- Төсвийн (орлого, зарлагын) төсөөллийн хүрээг боловсруулж дуусгах;
- Төсөөллийн чиглэлээр цуврал сургалт, семинар хийх талаар Сангийн яам, Монголбанк болон бусад холбогдох эрдэм шинжилгээ, судалгааны институтуудтэй гэрээлэх;
- Засгийн газрын зарлагад (ойрын өнгөрсөн түүхэн хугацааны болон төсөөллийн жилүүдийн) нөлөөлсөн хүчин зүйлүүдийн талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийж тайлан гаргаж хэвлүүлэх.

2022 онд:

- 2023 оны Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд (орлогын төсөөлөлд төвлөрөх) хийсэн үнэлгээний тайлан гаргаж хэвлүүлэх;

- Макро эдийн засгийн төсөөллийн загвар болон төсвийн төсөөллийн хүрээний нэгтгэсэн загварыг боловсруулж дуусгах;
- Жилийн төсвийн төсөлд хийх үнэлгээг боловсруулж хэвлүүлэх;
- Макро эдийн засаг, төсвийн төсөөллийн хүрээ, загварчлалын талаарх заавар, журмыг боловсруулж гаргах.

2023 онд:

- 2024 оны Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд (макро эдийн засаг болон төсвийн төсөөлөлд төвлөрөх) хийсэн үнэлгээний тайлан гаргаж хэвлүүлэх;
- Жилийн төсвийн төслийн үнэлгээг гаргаж хэвлүүлэх.

2024 онд:

- 2025 оны Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд (макро эдийн засаг болон төсвийн төсөөлөлд төвлөрөх) хийсэн үнэлгээний тайлан гаргаж хэвлүүлэх;
- Жилийн төсвийн төслийн үнэлгээг хийж хэвлүүлэх;
- Дунд болон урт хугацаанд Монгол Улсын төсөвт учрах сорилт, бэрхшээлүүдийн талаар тайлан гаргаж, хэвлүүлнэ;
- ТТБЗ-ийн төсөөллийн гүйцэтгэлийн үнэлгээг хийж хэвлүүлэх

ТТБЗ-ийн 2021- 2024 оны стратеги

1. ТТБЗ-ийн үйл ажиллагааны дүрмийг УИХ-ын 2017 оны 12 дугаар сарын 22-ны 83 дугаар тогтоолоор, Зөвлөлийн ажиллах журмыг УИХ-ын Төсвийн Байнгын Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор тус тус баталсан. Энэхүү дүрэм, журмыг орчуулан Дэлхийн банк, Олон улсын валютын санд хүргүүлж, тэдний санал зөвлөмжийг авч ажиллаж байна. Европын Холбооны санхүүжилттэйгээр Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд дотоодын зөвлөлтэй гэрээ байгуулан ажиллуулж, гадаад орнуудын тэргүүлэх туршлагыг судлуулж, ТТБЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, үйл ажиллагаандаа тусгуулахаар ажиллаж байна.
2. Дэлхийн Банкны зөвлөхийн тусламжтайгаар УИХ-ын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс болон ТТБЗ-ийн ажилтнуудад ОУВС-ийн макро эдийн засаг, төсвийн төсөөлөл боловсруулах, загварчлал болон түүхий эдийн үнийн төсөөлөл, тооцоолол хийх аргачлалын талаар чадавх бэхжүүлэх сургалт амжилттай зохион байгуулсан.
3. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр Төсвийн байнгын хороотой уулзалт зохион байгуулж Зөвлөлийн ажиллах хууль, эрхзүйн орчинг бүрдүүлэх, Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх, судалгаа хийх замаар хэрхэн хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах талаар хэлэлцсэн.
4. Макро-эдийн засаг, төсвийн болон төлбөрийн тэнцэл, инфляцын төсөөлөл боловсруулах сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтыг Монголбанк, Сангийн Яамтай хамтран зохион байгуулж байна.
5. Дэлхийн Банкны зөвлөмж, ЭЗХАХБ-ын сайн туршлага, жишээг судлан үзэж нэвтрүүлэх замаар ТТБЗ-ийн институтийн чадавхыг сайжруулах, мөн

гадаад, дотоодын эдийн засгийн судалгаа, шинжилгээний (МУИС, СЭЗИС г.м.) байгууллагуудтай хамтран төсвийн ил тод байдал, хяналт, төлөвлөлт, таамаглалыг сайжруулахаар ажиллаж байна.

6. Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг бэлтгэж, үнэлэх, макро төсөөлөл хийх, загварчлал боловсруулах ТТБЗ-ийн чадавхыг бий болгох зорилгыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд урьдчилсан техникийн зааварчилгаа, зөвлөгөөг Дэлхийн банкны бүрэлдэхүүн хэсэг хариуцсан экспертээс авч судалгааг эхлүүлсэн.
7. Дэлхийн банк, Европын холбоо нь Монгол улсын Засгийн газрын төсвийн сахилга бат, нийтийн/төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөн түүнчлэн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх хүчин чармайлтыг дэмжих зорилгоор “Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж холбогдох санхүүжилтийг олгохоор тохиролцсон юм.

ДӨРӨВ. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

Олон нийттэй харилцах, сурталчлах чиглэлээр телевиз, радио, сонин, сэтгүүл, цахим хуудсанд нийт 15 удаа ярилцлага өгсөн бөгөөд үүнээс дурдвал:

- Оюутолгойн гэрээнд оруулах өөрчлөлт (3 удаа)
- Улсын эдийн засаг, төсвийн байдал, анхаарах асуудал
- Төв банкны үйл ажиллагаа, мөнгөний бодлогын хэрэгжилт
- 2022 оны төсвийн төсөл
- Төлбөрийн тэнцэл, валютын ханшийн талаар
- Хямралын үеийн эдийн засгийн нөхцөл байдал
- Оюу толгойн гэрээгээр Монголын талын эрх ашгийн илүү хангах боломж
- Коронавирусын үед Засгийн газраас авах арга хэмжээ
- 2021 оны төсвийн явц биелэлтийн талаар ярилцлага өгсөн болно.

ТАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 онд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл өөрийн үйл ажиллагааны хүрээнд тайлант хугацаанд нийт 18 удаа хуралдаж, хуулийн төсөл болон бодлогын баримт бичгийн төсөлд санал, зөвлөмж гарган зөвлөлийн дүрэмд зааснаар хараат бус, бие даасан үнэлгээ, дүгнэлт гаргах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллалаа. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцсэн байна. Үүнд:

- Төсвийн гадуурх санхүүжилт, Дэлхийн банкны “засаглалыг бэхжүүлэх” төслийн дотоодын зөвлөхийн ажлын даалгавар, ТТБЗ-ийн 2020 оны жилийн эцсийн тайлан түүнд өгөх санал, OECD-ийн орнуудын Төсвийн зөвлөлийн үйл ажиллагаа, дотоодын 2 зөвлөхийн ажлын даалгавар, “Татварын боловсрол төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх нь” судалгааны ажил, Засаглалыг бэхжүүлэх төслийн ажлын явцын танилцуулга, Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд өгөх Зөвлөлийн санал,

зөвлөмж, 2022 оны төсвийн төсөл, Гадаад зөвлөхийн эцсийн тайлан, 2022 оны ТТБЗ хийх ажлын төлөвлөгөө зэрэг асуудлыг хэлэлцээд байна.

- УИХ-ын Төсвийн байнгын хороо, Дэлхийн банк, Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн нэгж, төслийн гадаад зөвлөхөөр ажилласан Паул Гардинер нартай олон удаагийн цахим уулзалт хийсэн.
- ТТБЗ-ийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, тулгамдаж буй сорилтыг тодорхойлох, мөн ТТБЗ-ийн дүрэм, журам, үйл ажиллагааг сайжруулах санал боловсруулж өнөөгийн төсвийн хууль тогтоомжуудад (Төсвийн тухай хууль болон Төсвийн Тогтвортой Байдлын тухай хууль, ТТБЗ-ийн үйл ажиллагааны талаарх УИХ-ын тогтоол гэх мэт) оруулах нэмэлт, өөрчлөлтийн боломжит санал, дүгнэлтүүдийг (ТТБЗ-ийн үйл ажиллагааны чадавх, хараат бус байдлыг хангах чиглэлээр) боловсруулав.

--oOo--

Тайлбар:

ⁱⁱ Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 69 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газраас өргөн мэдүүлсэн тухайн жилийн төсвийн төсөл, түүний тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон бусад хууль тогтоомжийн төслийн төсөвт нөлөөлөх байдалд хараат бус, бие даасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулж, зөвлөлийн дүрэм, гишүүдэд тавих шаардлага, томилох журмыг батлан гаргахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хооронд даалгасан байна. Энэ заалтыг хэрэгжүүлэх үүднээс Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны 83 дугаар тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсэн. *Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн:*

- 3.1.1-д Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн эрхлэх асуудалд УИХ-ын 2017 оны дээрх 69 дүгээр тогтоолоор тодорхойлсон ажил үүргээс гадна “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх тухай судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах”;
- 3.1.2-д “УИХ-ын холбогдох Байнгын хорооны хүсэлтийн дагуу шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргана”;
- 3.1.3-д “Зөвлөл гаргасан дүгнэлт, зөвлөмжөө УИХ-ын холбогдох Байнгын хороонд хүргүүлснээс хойш 3 хоногийн дотор олон нийтэд мэдээлж, тайлбар хийж болно”;
- 6 дугаар зүйлийн 6.1-д “Зөвлөл нь УИХ-ын Төсвийн байнгын хороог энэ дүрэмд заасан судалгаа, шинжилгээний дүгнэлт, зөвлөмж, холбогдох бусад мэдээллээр хангаж ажиллана”;

- 6.2-д “Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт болон үйл ажиллагааныхаа талаар хагас жил тутамд УИХ-ын Төсвийн байнгын хороонд тайлагнана”;
- 6.3-д “УИХ-ын Төсвийн байнгын хороо Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийн талаар шаардлагатай гэж үзвэл Засгийн газраас холбогдох тайлбарыг гаргуулж авна”;
- 6.4-д “Зөвлөлийн үйл ажиллагаанд УИХ-ын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана” гэж заажээ.

ii Ард түмний үнэмлэхүй олны санал авсан төрийн тэргүүний баялагтаа эзэн, импортоос экспортод гэсэн уриаг хэрэгжүүлэх учиртай. Монгол улсын хувьд хөгжлийн үндсэн гарц, ажлын байрны хангамж, гадаад өр зээлийн хүндрэлийг даван туулах гол хөшүүрэг болох экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэх явдал юм. Экспортыг дэмждэг Япон, Герман, Голланд, Солонгос, Хятад зэрэг орнууд өдгөө хөгжлөөрөө дэлхийг тэргүүлж байна.

Хавсралт №1

**“Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2
болон 6.1.4 заалтуудад оруулсан өөрчлөлтүүд**

Д/Д	Өөрчлөлт орсон хугацаа	6.1.2-т орсон өөрчлөлтүүд	6.1.4-т орсон өөрчлөлтүүд
Анхны батлагдсан хувилбар			
0	2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх;
Өөрчлөлт орсон хувилбарууд			
1	2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2015 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас, 2016 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувиас, 2017 онд тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас, 2018 оны төсвийн жилээс эхлэн тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх;	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд одоо байгаа түвшинд нь буюу 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 55 хувиас, 2017 оны төсвийн жилд 50 хувиас, 2018 оны төсвийн жилээс эхлэн 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх;
2	2015 оны 02 дугаар сарын 18-ны өдөр	-	<p>- 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаар нь уул уурхайн салбарын хуулийн этгээдэд Засгийн газар хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах зориулалттай бөгөөд тухайн хуулийн этгээдийн ашгаас эргэн төлөгдөх нөхцөлтэй байгуулсан гэрээний дагуу авсан Засгийн газрын зээл, эсхүл гэрээний энэхүү нөхцөлөөр гаргасан Засгийн газрын баталгаанд хамаарахгүй байх;</p> <p>- 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй байх;</p>
3	2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 онд 5 хувиас, 2016 онд 18.5 хувиас, 2017 онд 9.9 хувиас, 2018 онд 7.5 хувиас, 2019 онд 5.5 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2020 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг алдагдалгүй байлгах;	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3 хувиас, 2016 оны төсвийн жилд 88 хувиас, 2017 оны төсвийн жилд 85 хувиас, 2018 оны төсвийн жилд 80 хувиас, 2019 оны төсвийн жилд 75 хувиас, 2020 оны төсвийн жилд 70 хувиас, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх;

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны тайлан

4	2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;	-
5	2020 оны 07 дугаар сарын 07-ны өдөр	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх;	Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2021 болон 2022 оны төсвийн жилд 70 хувиас, 2023 оны төсвийн жилд 65 хувиас, 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх;

Хавсралт №2

**ТӨСВИЙН ГАДУУРХ САНХҮҮЖИЛТИЙГ ХЯЗГААРЛАХ ШААРДЛАГЫН ТУХАЙ
ТАНИЛЦУУЛГА**

2021 оны 01 дүгээр сарын 11

Коронавирусын хязгаарлалттай нөхцөл байгаа ч төсвийн гадуурх санхүүжилт хяналтаас гарч болзошгүй байдал бий болоод байна гэж Төсвийн тогтвортой байдлын зөвлөл үзэж, цаашид авах арга хэмжээний талаарх саналаа танилцуулж байна.

НЭГ. АЖЛЫН ХҮРЭЭ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хийх ажлын хүрээг хууль зүйн хувьд дараах байдлаар тогтоосон.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний 69 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газраас өргөн мэдүүлсэн тухайн жилийн төсвийн төсөл, түүний тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон бусад хууль тогтоомжийн төслийн төсөвт нөлөөлөх байдалд хараат бус, бие даасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулж, зөвлөлийн дүрэм, гишүүдэд тавих шаардлага, томилох журмыг батлан гаргахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хооронд даалгасан байна. Энэ заалтыг хэрэгжүүлэх үүднээс Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар 22-ны 83 дугаар тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсэн.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн:

- 3.1.1-д Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн эрхлэх асуудалд УИХ-ын 2017 оны дээрх 69 дүгээр тогтоолоор тодорхойлсон ажил үүргээс гадна “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэхэд судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах”,
- 3.1.2-д “УИХ-ын холбогдох Байнгын хорооны хүсэлтийн дагуу шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргана”,
- 3.1.3-д “Зөвлөл гаргасан дүгнэлт, зөвлөмжөө УИХ-ын холбогдох Байнгын хороонд хүргүүлснээс хойш 3 хоногийн дотор олон нийтэд мэдээлж, тайлбар хийж болно” гэж тус тус заажээ.
- 6 дугаар зүйлийн 6.1-д “Зөвлөл нь УИХ-ын Төсвийн байнгын хороог энэ дүрэмд заасан судалгаа, шинжилгээний дүгнэлт, зөвлөмж, холбогдох бусад мэдээллээр хангаж ажиллана”,
- 6.2-д “Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт болон үйл ажиллагааныхаа талаар хагас жил тутамд УИХ-ын Төсвийн байнгын хороонд тайлагнана”,
- 6.3-д “УИХ-ын ТБХ Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийн талаар шаардлагатай гэж үзвэл Засгийн газраас холбогдох тайлбарыг гаргуулж авна”,
- 6.4-д “Зөвлөлийн үйл ажиллагаанд УИХ-ын ТБХ-ны дэргэдэх Төсвийн шинжилгээний алба дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана” гэж заажээ.

Монгол Улсын Засгийн газар 2017 онд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, АХБ болон дэмжигч орнуудын өмнө Төсвийн тогтвортой байдлын зөвлөл байгуулах үүрэг авахдаа тус зөвлөлийн нэг чухал үүрэг нь “Төсвийн хязгаарлалтад орохоос зайлсхийхийн тулд төсвийн зарлага гаргадаг төсвийн гадуурх арга хэрэгсэл-механизм/тэдний нэрлэснээр “авто машин”/ бий болгож, ашиглах явдал гаргуулахгүй байхад оршино” гэсэн байгаа юм. Үүний санааг төсвийн цогц иж бүрэн байдал гэсэн утгаар УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 онд баталсан ТТБЗ-ийн ажлын журамд, төсвийн иж бүрэн байдлыг хангах судалгаа, шинжилгээ хийж санал дүгнэлт гаргана гэж заасан. (**Fiscal council**. An independent fiscal council comprising former Prime Ministers, Ministers, of Finance, and Governors of the Bank of Mongolia, and possibly other highly respected individuals, will be established under its own by end -December 2017(**structural benchmark**). The council will be nonpartisan, and while it will not be responsible for executing fiscal policy, it will prepare independent budget forecasts and costing of MPs’ policy proposals, will seek to verify that off- budget **vehicles** are not being used to circumvent budget limits, and will monitor compliance with the FSL. International experience suggests that such an institution can improve fiscal discipline and performance. In addition, we will make efforts to strengthen the National Audit Office Further)

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ХҮНДРЭЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Ковид-19 цар тахлаас үүсэлтэй эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг давахын тулд Монголын төр, засаг дотоод гадаадын санхүүгийн бүх сувгийг ашиглан тэмцэж байна.

Иргэдийнхээ аж амьдралын хүндрэлийг давах туулах, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих, татварын болон зээлийн дарамтыг хөнгөвчлөх үүднээс хүн амд очих бэлэн мөнгөний урсгалыг өргөжүүлж нэмэгдүүлэх, төсвийн зардлын санхүүжилтийг эрэмбэлж, эрүүл мэндийн салбарын техникийн чадавхыг нэмэгдүүлэх, цалин тэтгэвэр, хүүхдийн мөнгө, халамжид тасалдал гаргахгүй байх, иргэд аж ахуйн үндсэн хэрэглээ болсон цахилгаан, дулаан, ус, түлшний үнийг төрөөс хариуцах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн бусад татвар хураамжийг чөлөөлөх, багасгах, эдийн засагт нийлүүлэгдэх зорилтод хөрөнгө мөнгийг нэмэгдүүлэх, хямдруулах, зарим зээлийн төлбөрийг чөлөөлөх, хойшлуулах, нөхцөлийг нь өөрчлөх зэрэг олон төрлийн арга хэмжээ авч байна.

Энэ бүхэн юуны түрүүнд Монгол Улсын төсвийн үйл ажиллагаанд тусгалаа олж байна.

Монгол Улсын нэгдсэн төсөв 2020 оны эхний 11 сарын байдлаар 3.7 их наяд төгрөгийн алдагдалтай байгаа бөгөөд түүний 2.0 их наяд төгрөгийг гадаадын зээл тусламжаар санхүүжүүлж, үлдэх хэсгийг төсвийн өмнөх жилүүдийн нөөц хэмнэлтээс нөхсөн мэдээ байна.

Нэгдсэн төсвийн 2020 оны биелэлтийн явцаас үзэхэд орлогын татвар эхний 11 сард нийтдээ 572.2 тэрбум төгрөгөөр тасалдаж, нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дүн 664.0 тэрбум төгрөгөөр хэмжигдэж, харин гадаад худалдаатай голчлон холбогддог нэмэгдсэн өртгийн болон гаалийн татварын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэх төлөвтэй харагдаж байна. Дээр дурдсанчлан ковидын эсрэг төрөөс авсан санхүүгийн арга хэмжээний хүрээнд орлогын татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт наад зах нь 1.0 их наяд төгрөгт хүрч, хүн амын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн татварын дарамт багассан байх үндэстэй юм. Эрдэс түүхий эдийн үнийн өөрчлөлт экспортын болон төсвийн орлогод

нааштай нөлөө үзүүлсэн байх магадлалтай ч төр засгийн бодлого мөн чухал нөлөө үзүүлсэн.

Монгол Улсын засгийн газар, Монголбанкнаас цар тахлын хүндрэлийн үед гадаад худалдаанд тасалдал гаргахгүй байх, хөрш орнуудтай худалдааг хэвийн явуулах, экспортыг нэмэгдүүлэх, гадны зээл, тусламж, хөрөнгө оруулалт татах, зарим тулгамдсан өр төлбөрийг хойшлуулах талаар авсан шуурхай арга хэмжээний үр дүнд эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг даван туулж байна.

Орлогын тасалдал, санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдлын улмаас зарцуулахаар хуульчлан баталсан нэгдсэн төсвийн зарлага 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 85.5 хувийн биелэлттэй байгаагийн дотор хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ 61.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Ийнхүү төсвийн санхүүжилт дутуу байгаа нь нэг талаар хөрөнгө дутагдаж байгаа, нөгөө талаар ковид-19 цар тахлын тодорхойгүй орчинд төсвийн эрэмбийн дагуу гарах төсвийн зайлшгүй зардлын зүйл ангид үүсч болох эрсдэлээс сэрэмжилж буй хэрэг гэж ойлгож байна.

Нэгэнт төсөв дээр нэмэлт ачаалал өгөх боломжгүй байдлаас үүдэн төсвийн гадуур санхүүжилт гаргадаг механизмыг илүүтэй ашиглаж, дунд урт хугацааны төсвийн байдалд эрсдэл хүндрэл учруулж болзошгүй байна.

ГУРАВ. ТӨСВИЙН ГАДУУРХ ЗАРЛАГА ХЯНАЛТААС ГАРЧ БОЛЗОШГҮЙ БАЙДАЛ

Монгол улс 2012-2016 онд Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан ихээхэн хэмжээний төсвийн шинжтэй зардлыг гаргаж, төсвийн нэгдмэл байдлыг алдагдуулсан гашуун туршлага давтагдаж болзошгүй байна.

Төсвийн гадуурх зардал бий болсноор өрийг нэмэгдүүлэхээс гадна институцийн хувьд бодлогын зарчмууд алдагддаг, төсвөөс гадуур янз бүрийн зардлууд гарах орон зай үүсдэг.

ОУВС-тай Засгийн газар, Монголбанк 2017 оноос хамтарч хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилт”-ын хөтөлбөрийн хүрээнд төсвийн сахилга батыг бэхжүүлж, төсвийг нэгдмэл болгон 2020 оныг хүртэл амжилттай хэрэгжүүлсэн юм. Гэвч 2020 оноос дэлхий дахинд түүний дотор Монгол улсад дэгдсэн Ковид-19 цар тахлын сөрөг үр дагаврыг хөнгөвчлөх болон сонгууль зэрэг улс төрийн шалтгааны улмаас Монгол улс төсвийн ачааллаа даахгүй болж, төсвийн гадуурх санхүүжилт гаргаж, төсвийн хязгаарлалт, шалгуурыг тойрох явдал улам бүр газар авсаар байна. Ийм байдал гаргуулахгүй байх, түүнд судалгаа шинжилгээ хийж санал дүгнэлт гаргаж байх үүргийг дээр дурдсанчлан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд УИХ-аас баталсан дүрэм журмаар хүлээлгэсэн байдаг. Ковид-19 цар тахлын үеийн хүндрэлийг даван туулах болон эдийн засгийн идэвхийг алдагдуулахгүй байх зэрэг зориулалтаар Улсын нэгдсэн төсвөөс болон төсвийн гадуурх санхүүжилт, Монголбанкны мөнгөний бодлогын арга хэрэгслийн арга механизмаар дамжуулан нийтдээ 11.3 их наяд төгрөг цар тахлын үед зарцуулах тооцоо гарч байна. Үүнээс 2020 онд хамаарах нь 5.0 их наяд төгрөг, 2021 онд хүлээгдэж буй нь 4.3 их наяд төгрөг, цаашид үргэлжлэхэд нь 2.0 их наяд төгрөг шаардагдана. Хавсралт хүснэгт №3-д үзүүлэв. Энэхүү хавсралтаас үзэхэд төсвийн гадуур зардал гаргадаг арга механизмыг ашиглан хэрэгжүүлж буй арга хэмжээний нийт дүн 4.9 их наяд төгрөг болж, төсөвт дарамт учруулах эрсдэлтэй байна. Монголбанкнаас эдийн засагт оруулж буй мөнгө-репо санхүүжилт, мөнгөний бодлогыг зөөлрүүлснээс үүсэлтэй чөлөөлөгдөх мөнгө хөрөнгө, иргэдийн өр, зээлийн ачааллыг багасгах бүтцийн өөрчлөлт зэрэг арга хэмжээний мөнгөн илрэл болох 2.8 их наяд төгрөгийг төсвийн гадуурх зардлаар тооцоогүй болно. Харин Салхитын мөнгөний ордыг барьцаалан гаргасан бондын мөнгөжүүлэлтийг төсвийн гадуурх санхүүжилтэд тооцлоо.

Ийнхүү төсвийн гадуурх санхүүжилт дотроос уул уурхайтай холбогдсон төсөвт шууд нөлөөгөө үзүүлэх зардал нь 1.7 их наяд төгрөг байна. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарим аж ахуйн нэгж, суурин газрын иргэдийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг хариуцах 650.0 тэрбум, “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ийн ирээдүйд олох орлогыг барьцаалж, тэтгэврийн зээлийг тэглэхэд 694.9 тэрбум, тэтгэврийн зээлгүй байсан ахмадуудад 1 сая төгрөгийн тэтгэмж олгоход 215.5 тэрбум зэрэг зардлуудыг дурдаж болох юм.

Түүх сөхвөл Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банкны шугамаар төр засгийн шийдвэрээс улбаатайгаар 2012-2016 онуудад гарсан зардал, зээллэг, бонд зэргийг төсвийн гадуурх санхүүжилтэд Олон Улсын валютын сан хамааруулж, Улсын нэгдсэн төсвийн алдагдалд нэмж тооцож байжээ. Энэ агуулгын үүднээс авч үзвэл Монголбанкны хуримтлагдсан алдагдал, эргэн төлөлт нь саатаад буй Монгол Улсын Хөгжлийн банкны зарим зээл, УИХ-ын нэр бүхий гишүүдийн санал болгож буй өндөр хүүтэй зээлийн хүүний зөрүүг санхүүжүүлэхэд зориулан Засгийн газраас бонд гаргаж, Монголбанкинд байршуулах болон төрийн тэргүүний өрх бүрт нэг сая төгрөг олгох зэрэгт нийтдээ ойролцоогоор 6.0 их наяд төгрөгийн эх үүсвэр нь тодорхойгүй зардал байна. Үүнийг Хавсралт хүснэгт №4-өөс үзнэ үү.

Үүн дээр төсвийн гадуурх аргаар зарцуулаад буй 4.9 их наяд төгрөгийг нэмбэл нийтдээ бараг 11.0 их наяд төгрөг болж, энэ хэмжээгээр өр зээл нэмэгдэх эрсдэл байна.

Үүнээс дүгнэхэд өнөөгийн төсөв, санхүүгийн боломжоос хэтэрсэн зардал санхүүжилт санал санаачилга гарч байна. Үүнийг төрийн түшээд, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад ойлгуулж, дахин төсвийн гадуурх аливаа хэлбэрээр зардал, санхүүжилт гаргах ямарч боломжгүй болсон гэдгийг мэдүүлэх үүднээс дээрх тоон мэдээллийг толилуульж байна.

Нөгөө талаар эрдэс түүхий эдийн эрэлт, үнэ эдийн засгийн мөчлөг дагаж савлах магадлал бас их байдаг. Төсвийн болон валютын орлогын гол эх үүсвэр болсон нүүрсний экспортод торгон мэдрэмжтэй хандах шаардлагатай боллоо.

ОХУ-д нүүрсний экспортоо нэмэгдүүлэх дэд бүтцээ барьж их хэмжээний коксжих нүүрс экспортод юуны урьд БНХАУ, БНСУ, Японд гаргах болсон тухай хэвлэлийн мэдээ байна.

Бидний 2021 оны төсөв 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай түүнийг нөхөх эх үүсвэр бүрэн шийдэгдээгүй байна. Үүн дээр төсвийн гадуурх санхүүжилтээр шийдэгдсэн Хавсралт хүснэгт №3-д тусгасан 1.8 их наяд төгрөгийг нэмбэл төсвийн алдагдал 2021 онд 4 их наяд болно. Үүнээс гадна Хавсралт хүснэгт №4-т дурдсан эрсдэл үүсгэж буй 6 их наяд төгрөг байна. Үүний дотор Монголбанкны хуримтлагдсан алдагдал 3.8 их наяд төгрөг бол арилжааны банкуудын дампуурал, улс төрийн шийдвэртэй төсвийн шинжтэй санхүүжилтүүд, өндөр хүү, ханшийн эрсдэлтэй гадаад эх үүсвэрийн зардал зэргээс үүсэлтэйгээр нэгэнт гарсан төрөөс санхүүжилтээ хүлээж буй зардал юм.

Монголбанк энэ их алдагдлыг үүрээд яагаад тэсээд байна вэ гэхээр Монголбанкны Хятадын Ардын банкттай үндэсний валют солилцох гэрээг байнга сунгаж, эх үүсвэр нь Монголбанкинд ашиглагдаж байгаатай холбоотой юм. Хэрэв үүнийг төлбөл эх үүсвэр сох дутагдаж, Монголбанк хуульд заасны дагуу дээрх алдагдлаа төсвөөс нөхүүлж авахаас өөр аргагүй болно. Монголбанкнаас юаний свопын талаар хэвлэлд өгсөн тайлбарыг үзье. “Монголбанк, Хятадын Ардын банк хооронд байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох 15 тэрбум юанийн своп хэлцлийн ерөнхий гэрээг 2023 он хүртэл амжилттай сунгалаа. Своп хэлцлийн ерөнхий гэрээг сунгах ажлын

хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллаа. Тус гэрээг амжилттай сунгаснаар богино хугацааны гадаад өрийн дарамтыг эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр шийдвэрлэж чадав”. Гэвч энэ бол дахиад өрийг түр хугацаагаар хойшлуулж, нөгөө л хүүгээ дахин төлж, Монголбанкны зардал алдагдал өсөөд явна. Энэ бол жил бүхэн жил бүр 350-400 орчим тэрбум төгрөг бөгөөд асар их мөнгө буюу хөдөө, орон нутагт 100 орчим сургууль барих хөрөнгийг Хятадад шилжүүлж байна гэсэн үг юм. Ганц Монголбанк гэлтгүй Засгийн газар маань гадаад зээл, бондын төлбөрийг хойшлуулсан, хүүг нь бууруулсан гэж байгаа боловч хойшлуулсан буюу шинээр авсан зээлийн хүүний төлбөр улам бүр нэмэгдэж, нэг их наяд төгрөг рүү дөхлөө. Ийм нөхцөлийг бүрдүүлээд байгаад хэргийн учир байгаа юм. Учир нь төсвийн алдагдал хийгээд төсвийн гадуурх аливаа зардал Монгол Улсын Засгийн газрын өрийг нэмэгдүүлж, ард түмний нуруун дээрх ачаалал улам бүр даахын аргагүй болж байна. Үүнийг олон улсын банк, санхүүгийн байгууллага сайн санаа гаргаж, бидэнд олон удаа сануулж байгаагийн дотор саяхан хүртэл Дэлхийн банкнаас сануулсан нь хэвлэлээр гарсан. Харин манай түшээд үүнийг анзаарч нийтийн мөнгөөр, ямарч үнээр хамаагүй төсвийн болон төсвийн гадуурх зардлыг өсгөж өр зээлд оруулах аливаа санал санаархлыг зогсоож сонгогчдынхоо өмнөөс хариу тайлбар өгч байх нь чухал байна.

Эдийн засгийг сэргээхэд мөнгөний хэрэгцээ зайлшгүй байгаа учраас арилжааны банкууд дахь эх үүсвэрийг татах (Засгийн газраас ашигтай зүйлийн санхүүжилтэд зориулан бонд гаргах) боломжийг судалж болох боловч хүүний зөрүүг өнөөгийн нөхцөлд төсвөөс санхүүжүүлэх боломж огт байхгүй байна. Үүнээс гадна зээлийн болон хадгаламжийн хүүг сүүлийн 2-3 жилд тууштай буурч байна. Тухайлбал, зээлийн дундаж хүү 2016-2020 онд нийт 4 нэгж хувиар буурч 15.2 хувь болоод байна. Энэхүү хувь нь цаашдаа буурч сарын 1 хувь буюу жилийн 12 хувьд хүрэх стратеги зорилтыг УИХ-аас баталсан. Гэтэл 12 хувиас дээш хүүтэй зээлийн хүүгийн зөрүүг Улсын төсвөөс санхүүжүүлнэ гэвэл зээл, хүүг бууруулах төрийн бодлоготой төдийлөн нийцэхгүйн дээр ийм зорилготой мөнгийг 2021 он болон цаашид төсвөөс гаргах ямар ч боломжгүй байна. Нөгөө талаар мөнгө хүүлэлтээрээ ард түмний хамгийн их шүүмжлэл хүлээдэг ББСБ, барьцаалан зээлдэх зарим үйл ажиллагааны эх үүсвэр бүхий зээлийн хүүний зөрүүг улсаас хариуцна гэдэг бол нийгэмд сөрөг бухимдал үүсгэх талтай. Өөрөөр хэлбэл Банк, ББСБ-ын өндөр хүүний зөрүүг улсаас авах учраас зээл, хадгаламжийн хүүгээ бууруулахгүй байх механизм болно. Өдгөө хадгаламжийн хүү жилийн 10 орчим хувь болж өмнөх 3 жилээс 3 гаруй нэгж хувиар буураад байна. Цаашдаа ч энэ хувь инфляцийн түвшинд буюу 6-8 хувь хүртэл аяндаа буурах эдийн засгийн орчныг бүрдүүлэх нь чухал байна.

“Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг 2020 оны 8 дугаар сард Улсын Их Хурал (УИХ)-аар хэлэлцүүлэн баталсан. Энэхүү стратегийг 1) зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх, 2) зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, 3) банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах, 4) хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлээр боловсруулсан. Энэ хүрээнд Монголбанк, Засгийн газар болон бусад холбогдох байгууллагуудаас авч хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтуудыг тодорхой тусгасан. Энэхүү стратегид хүүний зөрүүг Улсаас санхүүжүүлэх заалт байхгүй байна.

Монголбанкны бодлогын хүү буурч 6 хувь болж, ийм хүүтэйгээр эдийн засагт мөнгө оруулах нь нэг талаас эдийн засгийг дэмжих, нөгөө талаас Монголбанк хүүгийн орлого олж, ашиг алдагдлаа зохицуулахад нь нэмэр болох юм. Харин энэ шийдвэрээ Монголбанк, түүний мэргэжлийн бүтэц бие даан шийдэхэд нь улс төрийн

нөлөө үзүүлэхийг хязгаарласан эрх зүйн зохицуулалтыг хатуу мөрдөж ажиллах хэрэгтэй болно.

Иргэд, аж ахуйн нэгжийн хадгаламжийн мөнгөний хэдий хэсгийг Төвбанк өөр дээрээ төвлөрүүлэх эсвэл буцаан гаргах нөхцөл байдлыг авч үзэх асуудал бол цэвэр мэргэжлийн байгууллагын ажил болно.

Монголбанкны гаргаж буй шийдвэрээс танилцуулбал:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны тогтоолоор жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарыг дэмжихэд зориулан Төв банкны репо арилжааны нөхцөлд өөрчлөлт оруулж, төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалан 2 хүртэл жилийн хугацаатай санхүүжилт олгох боломжийг бүрдүүлжээ. Улмаар 2020 оны 4 дүгээр улиралд 230 тэрбум төгрөгийн, 2021 оны 1 дүгээр улиралд нэмж 250 тэрбум төгрөгийн санхүүжилт банкуудад тус тус олгохоор шийдвэрлээд байна. Уг арга хэмжээ нь тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн эх үүсвэрийн зардлыг 10.5 хувь болгон, зах зээлийн хүүнээс 6-7 нэгж хувиар бууруулж, хугацааг уртасгах, зээлдэгчийн хүсэлтээр үндсэн төлбөрөөс эхний 6 сард чөлөөлөгдөх боломжийг олгож байна. Ингэснээр цар тахлын үед банкуудын зээл олголт доголдсон үед зээлийн нийлүүлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах, цаашид эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдолтой юм. Энэ бол Монголбанкны хэвийн зээл бөгөөд үүнийг алдагдалтай нөхцөлтэй буюу төсвийн шинжтэй, урьд өмнө гаргаж байсан санхүүжилттэй холбож болохгүй байна.

Монгол Улсын Засгийн газар, Монголбанк 2020 оны 5 дугаар сард ОУВС-ын “Шуурхай санхүүжилт”-ийн хөтөлбөрт хамрагдсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд 2020 онд 800.0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй төсвийн шинжтэй чанартай арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх, 2021 оноос төсвийн шинж чанартай санхүүжилтийг зогсоох гэсэн үүрэг авсан. Зөвхөн нэг удаагийн арга хэмжээ болгон 2020 оны хувьд цар тахлын нөхцөл байдал үүсэн, Монгол төрийн дээд удирдлагын шийдвэрийг хүндэтгэн дахин ийм эрсдэл гаргахгүй гэдэг итгэлээр Салхитын мөнгөний ордыг барьцаалсан өрийн бичиг-бондыг түр хугацаагаар мөнгөжүүлээд байна. Иймээс дээрх шуурхай санхүүжилтийн хэрэгслийн хүрээнд Монгол Улс олон улсын банк, санхүүгийн байгууллага, тэдгээрээр дамжуулан дэлхий дахины өмнө хүлээсэн үүрэгтэй хүндэтгэлтэй хандаж, эдийн засаг санхүүгийн хүндрэлийн үед тэдэнтэй дахин хэлэлцээнд орох нөхцөлийг хадгалж байх нь маш чухал болно. Тухайн үед гадаад талдаа үүсээд байсан манай орны нэр хүнд, тохиролцоогоо ашиглаж, зарим богино хугацаат гадаад өр төлбөрийг хойшлуулж, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “В”, ирээдүйн төлөвийг “Тогтвортой” хэвээр үнэлүүлж чадсан байна. Зээлжих зэрэглэл харьцангуй тогтвортой байгаа нь Монгол Улс гадаад, дотоод хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалж, Ковид-19 цар тахлын үед гадаад өрийн үйлчилгээг дахин санхүүжүүлэхэд дэмжлэг боллоо. Энэхүү нэр хүндийг өдгөө алдах нөхцөл бүрдэж болзошгүй байна. Хэрэв зээлжих зэрэглэл буурвал Монгол шиг өр зээл ихтэй, бас ойрын жилүүдэд их хэмжээний үнийн дүнтэй бонд зээллэгүүдийг шийдэх шаардлагатай орны хувьд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажиллах ёстой билээ.

Үндсэн хуулийн шинэ өөрчлөлтийн дагуу УИХ төсвийн алдагдлыг нэмэгдүүлж болохгүй, нөгөө талаар Засгийн газар хуульчлан баталсан он оны төсөв, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон хязгаар, нөхцөлийг хатуу мөрдөх, түүнд УИХ-ын Тамгын газар эрх зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай болохыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар хөндөгдөн яригдсан болохыг тэмдэглэж байна. УИХ-ын гишүүдийн өргөсөн мэдүүлсэн хууль тогтоомж болгоныг

хуульд нийцсэн эсэхийг сайтар авч үзэхгүйгээр хүлээн авч нийгэмд хүлээлт үүсгэж болохгүй гэж үзэж байна.

ДӨРӨВ. АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

4.1. Монгол Улс гадаадаас зээл, тусламжийг төсвийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд авах явдлаас аль болох зайлсхийж улс орны хөгжлийг дэмжсэн Монголд үр өгөөжөө өгөх төсөл хөтөлбөрүүдэд оруулах нь зүйтэй.

4.2. Монголбанкны мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих мөнгөөр хангах жирийн арга хэмжээг нэмэгдүүлэхийг дэмжиж байна. Наад зах нь 6 хувь буюу бодлогын хүүтэйгээр эдийн засагт зээл гаргаж энэ хүүгээрээ Монголбанкинд ашиглагдаж байгаа зарим эх үүсвэрийн зардлыг нөхөхийг хичээх нь зүйтэй. Тухайлбал, своп хэлцлийн хүрээнд жил бүр 400 орчим тэрбум төгрөгийг БНХАУ-д төлдөг. Нөгөө талаар Монголбанкны удирдлагаас ЖДҮ, уул уурхайн бус экспортын үйлдвэрлэлийг дэмжих зээлийн эрэлт байвал санхүүжүүлэх амлалт өгснийг анхааралдаа авах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл арилжааны банкнуудаас хямдхан эх үүсвэртэй зээлийн өсөлтийг Монголбанкинд гаргах эсэхийг хүлээх шаардлагатай гэж үзэж байна.

4.3. Дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийж төсөвт шууд болон цаашид дарамт учруулах, эргэх санхүүжилтийн санал, санаачлагыг хүлээн авахгүй байх. Төсвийн зарчмын бодлогоо алдуулахгүй байлгах. Төсвийн иж бүрэн байдлыг хангах, төсвийн гадуур зарлага гаргахыг зогсоох зэрэгт чиглэсэн тууштай бодлого явуулах, зайлшгүй арга хэмжээг цаг алдахгүйгээр авах, энэ талаар юуны түрүүнд УИХ, Засгийн газрын удирдлагын түвшинд сайтар авч үзэх, бодлогоо нэгтгэх нь чухал гэж үзэж байна.

4.4. ТТБЗ-ийн энэхүү товч танилцуулгыг Төсвийн байнгын хороо авч хэлэлцэн доорх шийдвэрийг гаргах:

- Төсвийн гадуур элдэв зардал гаргуулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах, энэ чиглэлээр гарч байгаа санал, санаачлагыг дэмжихгүй байх, учир, хор холбогдлыг тайлбарлах зэрэгт чиглэсэн ажлыг УИХ-ын байнгын хороод, Засгийн газраас зохион байгуулж байхыг заах.
- УИХ, Засгийн газраас одоогийн байдлаар төсвөөс гадуур үйлдвэр, байгууллагаас зардал гаргуулахаар тогтоосон шийдвэрүүдийн дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн орлогыг төрийн сангаар дамжуулан тусад нь тухайн байгууллагын нэрийн дансаар бүртгэж уг данснаас зарлагыг гаргаж хяналт тавьж байх. Ийм төрлийн гүйлгээг Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагад тусгаж байх арга хэмжээ авахыг Сангийн яаманд даалгах.
- Төсвийн хязгаарлалтад орохоос зайлсхийх шаардлагыг төсвийн гадуур гаргах арга хэрэгсэл (автомашины) бий болгоход чиглэсэн арга хэмжээ авахгүй байх. Энэ чиглэлийн санал, санаачлагад дүгнэлт хийж Төсвийн ирээдүйн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг судлан зохих дүгнэлт, саналаа Төсвийн байнгын хороонд танилцуулж байхыг ТТБЗ-д үүрэг болгох.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ДАРАМТЫГ ХӨНГӨВЧЛӨХӨД ЗОРИУЛСАН ТӨСВИЙН БОЛОН ТӨСВИЙН ГАДУУРХ САНХҮҮЖИЛТ, МӨНГӨНИЙ БОДЛОГЫН АРГА ХЭРЭГСЛИЙН ТҮҮВЭР

Хүснэгт 3.

/Тэрбум төгрөгөөр/

No	Зардлын нэр	Нийт дүн	2020 онд зарцуулсан хөрөнгө	2021 онд санхүүжих дүн	Шаардагдах хөрөнгө
НИЙТ ДҮН (I+II+III)		11,303.25	4,988.15	4,332.70	1,982.40
I.ТӨСВИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ		3,584.2	2,397.4	1,186.8	-
1	Хувийн хэвшлийн зарим аж ахуйн нэгж байгууллага, тэнд ажиллагсадын нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт	664.0	664.0		-
2	Хувийн хэвшлийн зарим аж ахуйн нэгжүүдийн ажилгүйдлийн даатгалын нөхөн төлбөрийн дэмжлэг 200 000 төгрөг	223.0	223.0	-	-
3	Хүн амын болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт	936.0	624.0	312.0	-
4	Улаанбуудай, элсэн чихэр зэрэг хүнсний болон хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, зарим бодисын гаалийн хөнгөлөлт, чөлөөлөлт	146.6	73.3	73.3	-
5	Малчдаас ноолуур худалдан авах урамшуулал	174.9	174.9	-	-
6	Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж сар бүр 100 000 (нэг зуун мянган) төгрөг олгох;	1,622.6	1,024.8	597.8	-
7	Хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичиг	97.05	61.4	35.7	-
8	Нийгмийн халамж, мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж сар бүр 288 000 төгрөг олгох.	384.0	216.0	168.0	-
II.ТӨСВИЙН ГАДУУР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ		4,958.0	1,102.8	1,872.8	1,982.4
1	Тэтгэврийн зээл тэглэхэд гаргасан бонд /Салхитын мөнгө, алтны орд/	694.9	694.9		
2	Өмнийн говийн төмөр замын бүтээн байгуулалт /Таван толгойн нүүрсний ордод ажиллаж буй улсын үйлдвэрийн газар/	2,553.2	394.1	424.6	1,734.5
3	Цахилгаан станцын барилгын санхүүжилт /Таван толгойн нүүрсний ордод ажиллаж буй улсын үйлдвэрийн газар/	675.4	-	427.5	247.9
4	“Сайжруулсан шахмал түлшний үнийн хөнгөлөлт	69.0	13.8	55.2	-
5	Зарим аж ахуйн нэгж, хот суурин газрын иргэдийн цахилгаан, дулаан, хог, усны зардлыг хариуцах /Эрдэнэт үйлдвэрийн “нийгмийн хариуцлага” –ийн хүрээнд/	650.0	-	650.0	-
6	Сургууль, цэцэрлэгийн нүхэн жорлон зэрэг ариун цэврийн байгууламжийг сайжруулах /Эрдэнэт үйлдвэрийн “нийгмийн хариуцлага” –ийн хүрээнд/	100.0	-	100.0	-
7	Тэтгэврийн зээлгүй байсан ахмадуудад нэг сая төгрөгийн тусламж /Салхитын мөнгө, алтны орд/	215.5	-	215.5	-
III.МОНГОЛБАНКНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ		2,761.1	1,488.0	1,273.1	-
1	Мөнгөний бодлогын хүрээнд зарцуулсан хөрөнгө	480.0	230.0	250.0	-
2	Монголбанк дахь Банкуудын заавал байлгах нөөцийг бууруулж 6 хувь болсноор чөлөөлөгдсөн арилжааны банкуудын эх үүсвэр	700.0	350.0	350.0	-
3	Төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулсантай холбогдож гарах иргэдийн хэмнэх мөнгө	315.9	126.3	189.6	-
4	Арилжааны банкуудын зээлийн бүтцийн өөрчлөлт хийсэн	1,265.2	781.7	483.5	-

ТӨСӨВТ АЧААЛЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ ЗАРДЛУУД

Хүснэгт 4.

/Тэрбум төгрөгөөр/

No	Зардлын нэр	Нийт дүн	Эх үүсвэр, тайлбар
НИЙТ ДҮН		6,018.60	
ЗАРИМ УЛС ТӨРЧДИЙН ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗАРДЛЫН ТООЦОО		1,247.4	
1	Өрх бүрт нэг сая төгрөгийн дэмжлэг олгох УИХ-ын тогтоолын төсөл	897.4	Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан УИХ-ын даргад өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл - оффшор бүсээс татагдсан хөрөнгийн эх үүсвэрээс төлнө.
2	Иргэн, ахуйн нэгжийн банк, банк бус санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүг 50 хувиас доошгүй хувиар бууруулан зөрүүг санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах	350.0	УИХ-ын гишүүн Г.Дамдинням нарын өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл
ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭМЖЛЭГ ШААРДЛАГАТАЙ ЗАРИМ ЗАРДЛЫН ДҮН		4771.2	
1	Монголбанкны хуримтлагдсан алдагдал, 2020 оны III улирлын байдлаар	3,807.2	Монголбанкны бодлогын болон бусад шалтгаанаар үүсэж буй алдагдал
2	Дэмжлэг шаардлагатай Монгол Улсын Хөгжлийн банкны зээлийн үлдэгдэл	964.0	Засгийн газрын шийдвэр нөлөөгөөр олгосон зарим зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байгаа

Хавсралт Хүснэгт 2а: ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (оноор)

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
<i>Сая ам.доллароор</i>	A	A	A	A	A	A	A	A	A	A	A	8
I. УРСГАЛ ДАНС	-885	-4,512	-5,381	-4,732	-1,934	-948	-700	-1,155	-2,207	-2,162	-675	-1,380
Кредит	3,733	5,050	5,020	4,886	6,468	5,517	5,978	7,141	8,461	9,184	8,358	5,773
Дебет	4,618	9,563	10,400	9,618	8,402	6,466	6,678	8,297	10,668	11,346	9,033	7,153
1.А Бараа ба үйлчилгээний худалдаа	-475	-3,517	-4,456	-3,918	-1,111	-153	0	278	-1,303	-834	305	-317
Кредит	3,394	4,577	4,452	4,478	6,078	5,137	5,605	6,801	7,668	8,416	7,646	5,340
Дебет	3,869	8,094	8,908	8,396	7,189	5,290	5,605	6,523	8,971	9,249	7,340	5,656
1.А.а Бараа	-172	-2,669	-3,030	-2,608	178	563	1,338	1,494	676	1,158	1,756	409
Кредит	2,908	4,056	3,800	3,789	5,471	4,446	4,804	5,834	6,557	7,183	6,991	4,869
Дебет	3,080	6,725	6,830	6,397	5,293	3,884	3,466	4,341	5,881	6,025	5,235	4,460
1.А.б Үйлчилгээ	-303	-848	-1,426	-1,310	-1,289	-715	-1,338	-1,216	-1,978	-1,992	-1,450	-726
Кредит	486	521	652	689	607	691	801	966	1,112	1,233	655	471
Дебет	789	1,369	2,077	1,999	1,896	1,406	2,139	2,182	3,090	3,224	2,105	1,196
1.В Анхдагч орлого	-598	-1,243	-1,167	-963	-973	-970	-911	-1,613	-1,228	-1,569	-1,253	-1,207
Кредит	30	43	61	52	57	59	68	76	346	394	341	230
Дебет	627	1,286	1,227	1,015	1,030	1,028	980	1,689	1,573	1,963	1,595	1,436
1.С Хоёрдогч орлого	187	248	242	149	150	174	212	180	324	241	273	144
Кредит	309	430	507	355	333	321	305	264	448	374	371	204
Дебит	122	182	265	207	183	147	93	85	124	134	98	60

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

--oOo--

**НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ДЭРГЭДЭХ ТӨСВИЙН ЗӨВЛӨЛӨӨС
ТӨСВИЙН ГАДУУРХ САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙЖ,
ХУРААНГУЙЛСАН МЭДЭЭЛЭЛ**